



ACHIT IKHT LLC

MEMBER OF   
An HKEX Company

“АЧИТ-ИХТ” ХХК-ИЙН  
ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ  
КАТОДЫН ЗЭСИЙН ҮЙЛДВЭРИЙН  
2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: UN-000001/

/Регистрийн дугаар: 2788705/

Хянасан:

ХБОБНУГ-ын мэргэжилтэн \_\_\_\_\_/

Биелэлтийг тайлагнасан:

“Ачит-Ихт” ХХК-ийн үйлдвэрийн захирал \_\_\_\_\_/И.Батболд/

“Ачит-Ихт” ХХК-ийн ХАБЭАБО-ны хэлтсийн байгаль орчны ажилтан Т. Нарангэрэл /Т.Нарангэрэл/



2022 он

## Гарчиг

|  |    |
|--|----|
| 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....  | 2  |
| 1.1. Төсөл хэрэгжүүлэгчийн засаг, захиргааны харьяалал .....   | 2  |
| 1.2. Төслийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн мэдээлэл.....   | 3  |
| 1.3. Төслийн түүхэн товчоо.....  | 3  |
| 1.4. Төслөөс байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, холбогдох зөвшөөрлүүд                 | 4  |
| 1.5. Төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүтэц, нийт төсөв.....                              | 5  |
| 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ   | 6  |
| 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....   | 9  |
| 4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ   | 10 |
| 5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ                                     | 11 |
| 6. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....  | 12 |
| 7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....   | 14 |
| 8. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН<br>ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... | 15 |
| 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ.....  | 16 |
| 10. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХУВААРЬ                               | 18 |


# 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

## 1.1. Төсөл хэрэгжүүлэгчийн засаг, захиргааны харьяалал

Төслийн байршил: Катодын цэвэр зэс боловсруулах үйлдвэр нь Эрдэнэт хотоос 15 км-т, Орхон аймгийн Баян-Өндөр сумын Баянцагаан багийн нутаг дэвсгэр, Эрдэнэт үйлдвэрийн үйлдвэрийн бүсэд байрлана.

Зураг 1. Төслийн байршлын зураг

Төслийн ангилал: Ачит-Ихт ХХК-н үйлдвэр зэсийн бага агууламжтай 2-р овоолгоос L-SX-EW технологи ашиглан катодын цэвэр зэс гаргаж авах төсөл бөгөөд 2014 оноос үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн, тогтмол явагдаж байна.



## 1.2. Төслийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн мэдээлэл

*Хүснэгт 1. Ачит-Ихт ХХК-ийн аж ахуйн нэгжийн мэдээлэл*

| Төслийг хэрэгжүүлэгч | Улсын бүртгэлийн дугаар | Үйл ажиллагааны чиглэл  | Төслийн хаяг байршил  | Төсөл хэрэгжүүлэгчийн Хаяг байршил  |
|----------------------|-------------------------|---|---|---|
| Ачит-Ихт ХХК         | 9011190055              | Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт байрлах ТӨҮГ-н 2-р овоолгыг түшиглэн катодын зэс үйлдвэрлэх | Эрдэнэт хотоос 15 км, уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрээс 4км-т хойд өргөргийн 49°1'18", Зүүн уртрагийн 104°10'58" координат буюу Орхон аймгийн Баян-Өндөр сум, Баянцагаан багийн нутагт, Төмөр замын Эрдэнэт өртөөнөөс 5км зайд оршино. | Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Стадион оргил-1, Чингисийн өргөн чөлөө-6, Кей Би Таур, 21 давхар<br>Утас: 75951155 |

## 1.3. Төслийн түүхэн товчоо

*Төсөл эхэлсэн огноо:* Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь балансын бус хүдрийн хоёрдугаар овоолгод 1978 оноос 2005 оны хооронд 0.307%-ийн агуулгатай 199.230 тн металл зэстэй, 65.0 сая тн хүдэр байршуулсан. “Ачит-Ихт” ХХК хүдрийн нөөцийг шүлтгүйжүүлэлтийн технологиор боловсруулах арга замыг бүх талаас нь судалсны үндэнд үйлдвэр байгуулах шийдвэр гаргаж, 2014 оны 5/330-14 тоот гэрээгээр 0.31%-ийн агуулгатай 173,998.9 тн металл зэстэй 56.0 сая тн балансын бус хүдрийг шилжүүлэн авсан.

*Хүснэгт 2. Үйлдвэрийн түүхий эдийн нөөц, түүнээс гаргаж авах зэсийн хэмжээ:*

| №   | Үзүүлэлт  |          | Нэгж    | Хэмжээ   |
|-----|---|----------|---------|----------|
| 1   | Үйлдвэрийн балансад авсан хүдрийн нөөц                      | Хүдэр    | мян. тн | 56000.9  |
|     |   | Эзлэхүүн | мян. м³ | 29699.72 |
|     |   | Зэс      | Тн      | 173998   |
|     |   | Агуулга  | %       | 0.31     |
| 2   | Үүнээс 1983-2004 оны хооронд угаагдаж үл хөрсөнд суусан зэс |          | тн      | 1782     |
| 3   | 2017 оны 7-р сарын 1 -д батлагдсан нөөц овоолгод үлдсэн зэс |          | тн      | 135668.8 |
| 3.1 | Хүдэр   |          | Мян.м3  | 29699.7  |
| 3.2 | Исэлдсэн зэс  |          | тн      | 26219    |
|     |   |          | %       | 19.3     |
| 3.4 | Ашиглалтын бүх хугацаанд гаргах катодын зэс                 |          | тн      | 86056    |

*Төсөл хэрэгжих хугацаа:* 52.0%-ийн зэс авалттайгаар 10 жилийн туршид 86056 тн катодын зэс гаргахаар төлөвлөн ажиллаж байна.



Төслийн техник эдийн засгийн үндэслэл:

1. 2014 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 14-15-08 тоот дүгнэлтээр хүлээн авч Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлын хурлаар Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт орших “Ачит-Ихт” ХХК-ийн Катодын зэсийн үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэж, 2014 оны 10 дугаар сарын 28-өдрийн Ашигт малтмалын газрын даргын Т-37 тоот тушаалаар Катодын зэсийн үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл батлагдсан.
2. 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлын хурлаар төслийн техник эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хэлэлцүүлэн БҮ-2019-01-01 тоот дүгнэлтээр хүлээн авсан.

#### 1.4. Төслөөс байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, холбогдох зөвшөөрлүүд

*Хүснэгт 3. Ачит-Ихт ХХК-ийн эзэмшдэг зөвшөөрлүүд, улсын байгууллагын дүгнэлтүүд*

| №  | Тусгай зөвшөөрлийн төрөл  | Дугаар               | Огноо                      |
|----|---|----------------------|----------------------------|
| 1  | Аж ахуйн нэгжийн гэрчилгээ  | 9011190055           | 2014.02.28                 |
| 2  | Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл                                   | 0001624<br>0001625   | 2020.04.21-2023.12.31      |
| 3  | Газрын чанарын хянан баталгаа   |                      | 2015<br>2020               |
| 4  | Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт              | 11/2656<br>13/4334   | 2016.05.03<br>2019.06.20   |
| 5  | Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ                    | БОАЖНХЯ              | 2016.07.08                 |
| 6  | Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол | БОАЖНХЯ              | 2017.05.31<br>2019.06.18   |
| 7  | Газар эзэмшүүлэх гэрээ  | 5/330-14             | 2014.09.08                 |
| 8  | Ус ашиглуулах дүгнэлт<br>Ус ашиглах гэрээ                               | 01<br>07             | 2021.04.02<br>2022.02.14   |
| 9  | Химийн бодисын агуулахын магадлалын ерөнхий дүгнэлт                     | 119/2017             | 2017.04.03                 |
| 10 | Химийн бодисын агуулахын баталгаажуулалт. /Улсын байцаагчийн дүгнэлт/   | 14-04-004/160        | 2017.12.12                 |
| 11 | Химийн бодис хадгалах агуулахын байршил тогтоох захирамж                | А/640                | 2014.12.09                 |
| 12 | Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт                              | 01804846<br>01804849 | -<br>2021.02.08-2023.02.08 |

### 1.5. Төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүтэц, нийт төсөв

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавилаа.

2019 оны БОАЖ сайдын тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг удирдлага болгон ажиллаж байна. 2022 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээ, нөхөн сэргээлтийн ажлын зардалд нийт 85.740.000 / наян таван сая долоон зуун дөчин мянган / төгрөг төсөвлөсөн байна.

*Хүснэгт 4. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардлын задаргаа, төсөл тус бүрээр*

| №           | Төслийн нэр   | Биелэлт /хувиар/ | Төлөвлөсөн Зардал | Зарцуулсан төсөв     |
|-------------|---|------------------|-------------------|----------------------|
| 1           | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ                                  | 92               | 8'500'000         | 13'650'000           |
| 2           | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ   | 100              | 24'000'000        | 13'282'000           |
| 3           | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ   | 100              | 15'600'000        | 746'000'000          |
| 4           | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө                                 | 100              | 1'000'000         | 1'000'000            |
| 5           | Хог хаягдлын менежмент  | 100              | 25'400'000        | 29'442'000           |
| 6           | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь | 100              | 1'000'000         | -                    |
| 7           | Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө                               | 100              | Тогтсон зардлаар  | 336'394'800          |
| 8           | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр                                      | 100              | 10'240'000        | 7'880'000            |
| <b>Нийт</b> |   | <b>99</b>        | <b>85'740'000</b> | <b>1'147'648'000</b> |

## 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Энэ бүлгийн зорилго нь төслөөс үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлж, үргэлжлэх эрчим ба цар хүрээг тогтоох нөлөөллийг бууруулах буюу зайлсхийх, багасгах, нөхөн сэргээх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр зорьж ажиллав.

Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

| №  | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд  | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ                 | Биелэлт   | Хувь |
|--|---------------------------------------|---|---|------|
| <b>Агаарын чанар</b>                       |                                       |   |   |      |
| 1  | Уурын зуухны үнс утаа                 | Уурын зуухны утаанд агуулагдах бохирдуулагчийг тодорхойлох      | MNS4048-88 аргын стандартаар агаарын 5 цэгээс дээж авч химийн шинжилгээ хийж хүхэрлэг хий, азотын дахвар исэл үзэхэд MNS 4585:2016 стандарт дахь хүлцэх агууламжаас даваагүй байна.<br><br>/Хавсралт 1/   | 100  |
| 2  | Овоолго /бороожуулах, исэлдэх ууршах/ | Үйлдвэрийн 6-н байршилд агаарын шинжилгээ хийлгэх.              | УЦУОШТ-р 22/63-А тоот гэрээний дагуу MNS4585:2016 стандартын дагуу тогтсон хугацаанд шинжилгээ хийлгэсэн бөгөөд стандартыг давсан тохиолдол байхгүй байна. /Хавсралт 2/   | 100  |
| 3  | Нүүрс ачиж буулгах талбай             | Орчны агаар дахь тоосжилт хийлгэх                               | Агаар дахь тоосжилт хэмжих ажлын хүрээнд MNS17.2.512:88 аргын стандартаар DUSTRAK8530 төхөөрөмжөөр үйлдвэрийн 5 цэгээс дээж авч Сэлэнгэ аймгийн УЦУОШТ лабораторит SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , TSP нийт тоос шинжилгээ хийлгэж MNS4585:2016 стандартыг давсан тохиолдол байхгүй байна. /Хавсралт 3/   | 100  |
| <b>Гадаргын ба газрын доорхи усны нөөц</b> |                                       |   |   |      |
| 4  | Хаягдал усны шинжилгээ хийлгэх        | Цэвэрлэгдсэн бохир усанд хөндлөнгийн хяналт шинжилгээг хийлгэх. | 2022 онд цэвэрлэх байгууламжийн оролт, гаралт усны шинжилгээг улирал тутамд “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-н итгэмжлэгдсэн лабораториор гүйцэтгүүлж, цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгээ үйлчилгээний ажлыг улирал бүр тогтмол цэвэрлэж байгууламжийн био реактор танкны лагийг соруулж, угааж цэвэрлэж байна. Цэвэрлэсэн бохирдлыг төв цэвэрлэх байгууламж руу тээвэрлэн хүргэдэг.<br><br>/Хавсралт 4/ | 100  |

|                       |   |  |  |     |
|-----------------------|---|--|--|-----|
| 5                     | Овоолгоос урсах уусмал                  | Гүний усанд нэвчилт үүсэж байгаа эсэхт хяналт тавих  | Үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 7 хоног бүрийн мягмар гарагт гүний усны хяналтын цооногт усны түвшингийн хэмжилтийг тогтмол явуулж байна. Одоогоор огцом өсөлт бууралт ажиглагдаагүй. 2022 оны 10 дугаар сарын 25 байдлаар 43 удаа 344 дээжлэлт хийсэн байна. Сар бүр хөндлөнгийн хяналтаар УЦУОШТ гэрээний дагуу хяналт хийсэн. /Хавсралт 5/  | 100 |
| 6                     | Цөөрөм                                  | Цөөрмийн налуугийн хяналт тавих  | Цөөрмийн налуугийн хяналтын дээж 2-р долоо хоног бүрийн пүрэв гарагт үзлэг хийж шингэн илэрсэн тохиолдолд дээж авч шинжилгээ хийдэг. Жилийн хугацаанд 26 -н удаагийн давтамжтайгаар 208 үзлэг хяналт хийсэн байх болно.  | 100 |
| <b>Хөрсөн бүрхэвч</b> |   |  |  |     |
| 7                     | Хөрсөнд хаягдал тос асгарах             | Хаягдал шатах, тослох материалыг тусгайлан тосон авч, зөвшөөрөл бүхий байгууллагад хүргүүлэх | Шатах, тослох материалын хаягдлыг тусгайлан цуглуулж “Монпити ойл” ХХК-д 2018 оноос хойш тогтмол нийлүүлж байна. 2022 онд 1200л хаягдал тос хүргэж өгсөн байна. /Хавсралт 6/   | 100 |
| 8                     | Хуурайшилт ихтэй үед замын тоос босох   | Замыг усалж тоос дэгдэхээс сэргийлэх   | Замыг усалж тоос дэгдэхээс сэргийлж "Тэнүүн Төвөргөөн" ХХК -тэй гэрээ байгуулж 6,7,9,10 дүгээр саруудад зам усалгаа хийсэн.  | 100 |
| 9                     | Уусмал хөрсөнд нэвчих                   | Хөрсөн бүрхэвчийн 5 хяналтын цэгээс хүнд болон бусад элемент тодорхойлох                     | Хөрсөн бүрхэвчийн 5 хяналтын цэгээс жилд 2-р удаа хүнд болон бусад элементийг хөндлөнгийн шинжилгээ хийлгэсэн.   | 100 |
| <b>Газрын хэвлий</b>  |   |  |  |     |
| 10                    | Үйлдвэрийн бүсд хатуу хог хаягдал үүсэх | Эко өдөрлөгийг тогтмол хэрэгжүүлэх   | Үйлдвэрийн барилга байгууламж, орчныг цэвэрлэх өдөрлөгийг тогтмол зохиож ахуйн хог хаягдал цугларахаас сэргийлэх ажлын хүрээнд жил бүр нийтийн цэвэрлэгээний өдрийг тохиолдуулан үйлдвэрийн ашиглалтын нийт талбайг цэвэрлэх, хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор “Эко өдөрлөг”-ийг 2015 оноос хойш жил бүр үйлдвэрийн нийт ажилтнуудыг хамруулан тогтмол зохион байгуулж байна. 2022 онд өдөрлөгийг амралтын өдөр зохион байгуулсан бөгөөд нийт 84 гаруй ажилтан оролцож, Алтантэвшийн хөндийд 17га талбайг самнаж хог түүсэн. /Хавсралт 9/ | 100 |

|                     |                                  |   |  |           |
|---------------------|----------------------------------|---|--|-----------|
| 11                  | Газрын хэвлий хөндөхөөс сэргийлж | Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж “Ухалт малталтын ажлын зөвшөөрөл”-ийг холбогдох журмын дагуу өгч, бүртгэл хөтлөх | Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж “Ухалт малталтын ажлын зөвшөөрөл”-ийг холбогдох журмын дагуу өгч байгаа бөгөөд 2022 онд 6ш зөвшөөрөл олгож ажилласан. /Хавсралт 10/   | 100       |
| <b>Амьтны аймаг</b> |                                  |   |  |           |
| 12                  | Уусмалын цөөрөмд шувуу орох      | Уусмалын цөөрөмд шувуу үргээгч суурилуулж хянах   | Цөөрмийн эрэгт 2018-2021 он хүртэл шувуу үргээгч байрлуулж ажиллуулсан бөгөөд 2022 онд шинээр шувуу үргээгч авахаар судалсан боловч цөөрмийн ууршуулалт хийж эхэлснээр шувуу үргээгч суурилуулах шаардлагагүй болсон.                                | 0         |
| <b>Уур амьсгал</b>  |                                  |   |  |           |
| 13                  | Хур бороо, үер буух              | УЦУОШГ-тай хамтарч мэдээллийн сан үүсгэх. Бороо ус ихтэй үед урьдчилан сэргийлж тогтмол цаг агаарын мэдээ авах          | Үерийн суваг, байгууламжийн бэлэн байдлыг хангаж 1600м суваг шуудуй сэргээсэн. 2022 онд сар бүр тухайн сарын цаг агаарын урьдчилсан мэдээг УЦУОШТ-с авч ажиллав. Сар бүрийн төгсгөлд хур тунадасын гүйцэтгэл авч мэдээллийн сан үүсгэв./Хавсралт 11/ | 100       |
|                     | <b>Нийт</b>                      | <b>8'500'000</b>  | <b>13'650'000</b>  | <b>92</b> |

Жич: Үйл ажиллагааны зардалд тусгасан зардал нь “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээ, нөхөн сэргээлтийн ажлын зардалд” ороогүй болно. ОХШХ-т тусгасан зардал нь 9 дугаар бүлэг дэх Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан болно.

### 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Техникийн нөхөн сэргээлт нь биологийн нөхөн сэргээлт буюу биологийн олон төрөл зүйл тухайн газар эргэн нутагших экосистемийг сэргээх цогц үйл ажиллагааны үндэс суурь болдог. “Ачит-Ихт” ХХК нь техникийн нөхөн сэргээлтийг цаг тухайд нь хариуцлагатай гүйцэтгэхийг эрмэлзэн мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Биологийн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд 2022 онд Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж үйлдвэрийн орчим мод тарьж ногоон бүс байгуулахаар зорьж байна.

Хүснэгт 6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

| № | Нөхөн сэргээлтийн зорилт | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ   | Биелэлт   | Хувь       |
|---|--------------------------|---|---|------------|
| 1 | Биологийн нөхөн сэргээлт | Үйлдвэрийн бүсэд PLS цөөрмийн ойролцоо ботууль зүлэг, олон наст тарьж Биологийн нөхөн сэргээлтийг хийх. | 2021 онд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд биологийн нөхөн сэргээлт 0.5 га талбайд хэрэгжүүлж шимт хөрсөөр хучсан талбайд олон настын үр цацав. Нийт ургалт 76% бөгөөд зорилтот зүйл 30%-д үйлдсэн хөл газрын ургамал ургаж ногоон масс нэмсэн байна. | 100        |
| 2 | Биологийн нөхөн сэргээлт | Үйлдвэрийн хашаанд зам дагуу навчит мод суулгах   | Мод үржүүлгийн газарт хашаа байгуулж хаврын улирал ногоон зурвас үүсэх байдлаар 3000ш хайлаас, 200ш шинэс мод суулгав. Намар нь 66ш нарс, 44ш агч, 22 жимсний мод тарив.  | 100        |
|   | <b>Нийт</b>              | <b>24'000'000</b>   | <b>13'282'000</b>   | <b>100</b> |

“Ачит-Ихт” ХХК нь 2014 оноос эхлэн “Бүх нийтээр мод тарих” үндэсний өдрийг тэмдэглэн үйлдвэрийн талбайд ногоон байгууламж байгуулах ажлыг ажилтнууд болон гэрээт мэргэжлийн байгууллагатай хамтран өрнүүлэхээс гадна тус үйл ажиллагааг өргөжүүлэн тэлж Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Сум дундын ойн ангитай хамтран өөрийн компанийн нэрэмжит төгөлтэй болох зорилгоор Сархиа уул, хотын А1001 зам дагуу мод тарих ажлуудыг зохион байгуулж байна. Цаашид бид үйлдвэр орчимд тарьсан 6000 гаруй моддын арчилгааг дулааны улиралд гэрээт ажилтнаар арчлуулж, моддын болон орчны ногоон байгууламжийн амьдралын үр дүнг өндөр байлгах ажлыг тогтмол зохион байгуулна.



#### 4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

“Ачит-Ихт” ХХК-ийн катодын зэс ялган авах төсөл нь нутгийн биологийн олон янз байдалд эерэг нөлөө үзүүлэхийг эрмэлзэж байна. Үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн биологийн олон янз байдалд учирч болох эрсдэл буюу болзошгүй сөрөг нөлөөллийг шатлалтайгаар бууруулах зарчмыг баримталж зохион байгуулах.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар Зарлигийн дагуу “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд” 2022-2030 онд 3,0 сая модны тарьц суулгацын нөөцийг бүрдүүлэх зорилгоор мод үржүүлгийн газрын төслийг боловсруулан Орхон аймагт хэрэгжүүлж эхэлнэ.

Хүснэгт 7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

| №           | Дүйцүүлэн хамгаалах зорилт             | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ   | Биелэлт  | Хувь       |
|-------------|--|---|--|------------|
| 1           | Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх | Гурван замын ногоон зурвасанд 2019-2021 онд тарьсан моднуудын ургалт, хамгаалалтанд онцгой анхаарч нөхөн тарилт болон хамгаалалтын хашааг засварлаж шинэчлэх                            | А1001 зам дагуу ногоон зурвас байгуулах дүйцүүлэн хамгаалах 1.4 га талбайн 980м хашааг өргөстэй тороор 4 эгнээ торлож хүчитгэв. 275 хайлаас модыг нөхөн тарилтыг хийв. /Хавсралт 12/ | 100        |
| 2           | Булаг шандын эхийг хамгаалах           | Баян-Өндөр сумын Баянцагаан багийн нутаг дэвсгэр дэх Хөөврийн рашааны усны хими, физик, бактериологийн шинжилгээг хийлгэж, тогтмол хяналт тавин хамгаалалтын хашааг засварлаж шинэчлэх. | Хөөврийн булгийн сэтгэрсэн чулуун хашаан чулууг өрж нөхөв. Мэргэжлийн хяналтын лабораторид Хөөвөр, Далиу булгийн усны шинжилгээ хийлгэв. /Хавсралт 13/                               | 100        |
| 3           | Суулгац бэлдэх                         | Модны тарьц суулгацын нөөцийг бүрдүүлэх зорилгоор мод үржүүлгийн газар байгуулах  | “Далайн Хошууны Шинэс” нэртэй мод үржүүлгийн газар байгуулж 460мянган үрсэлгээ үрслүүлэв.  | 100        |
| 4           | Мод тарих                              | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Хавар, Намрын бүх нийтээрээ мод тарих өдрүүдээр орон нутгаас зааж өгсөн газарт мод тарьж арчилан ургуулж хамгаалах                              | Дүйцүүлэн хамгаалах гурван замын ногоон зурваст 1.4га талбайн хашааг шинэчлэн засварлаж шинээр 1.5 дээш өндөртэй 1000 ширхэг хайлаас, моднуудыг суулгав.                             | 100        |
| <b>Нийт</b> |  | <b>15'600'000</b>   | <b>746'000'000</b>   | <b>100</b> |

“Ачит-Ихт” ХХК нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас газар ашиглах гэрээний дагуу 157.16 га талбайг ашиглах зөвшөөрөлтэй ба нийт 156.96 га талбай ашиглалтын идэвхтэй хэлбэрт байна.

## 5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Гамшгийн үед компанийн үйлдвэрийн оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг гамшгаас хамгаалах ерөнхий төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх ба гамшгийн эрсдэлд өртөж эрүүл мэндээрээ хохирох эрсдэлийг даатгалын журмаар зохицуулах ба эрсдэлд өртсөн тохиолдолд хууль тогтоомжийн дагуу нөхөн олговор олгож ажиллав.

Хүснэгт 8. Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө

| № | Төлөвлөгөөтэй эсэх   | Хүн, хүчний тооцоо /штаб, мэргэжлийн анги/         | Химийн хорт бодисын нэр, тоо хэмжээ  | Техник хэрэгсэл |                               | Бэлэн байдлын үеийн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл /төрөл, тоо ширхэг/ |                       |               |              |            |               |               |
|---|--|--|--|-----------------|-------------------------------|---|-----------------------|---------------|--------------|------------|---------------|---------------|
|   |  |  |  | 3               | 13                            | 10  | 100                   | 25            | 200          | 1000       | 20            | 1             |
| 1 | “Ачит-Ихт” ХХК-ний гамшгаас хамгаалах ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу | Удирдлага<br>Штаб: 9хүн<br>Мэргэжлийн анги: 20 хүн | Хүхрийн хүчил:<br>H <sub>2</sub> SO <sub>4</sub> – 6385 тн<br>Органик хандлагч<br>Ликс: 55 тн<br>Кобальтын сульфат:<br>19тн<br>Гуартек: 4.5 тн<br>Керосин:500 тн | Автобус         | Том оврын болон суудлын тэрэг | Хүчлээс хамгаалах хувцас MSA SAFETY                                   | Резинэн бээлий 20х200 | Резинэн гутал | Хошуувч- P-2 | Амны хаалт | Нүүрний хаалт | Хороглох байр |

**Нөхөн олговрыг шийдвэрлэх төлөвлөгөө**

| № | Нөхөн олговрыг шийдвэрлэх арга хэмжээ       | Ажилтны тоо   | Нэг ажилтны даатгалын зардал | Нийт зардал    | Даатгалын компани |
|---|---|---|------------------------------|----------------|-------------------|
| 1 | Ажил олгогчийн даатгал                      | 184   | 44,861,972                   | 10,462,602,936 | Бодь-Даатгал      |
| 2 | Гэнэтийн ослын даатгал                      |   | 10,000,000                   |                |                   |
| 3 | Эмчилгээний даатгал                         |   | 2,000,000                    |                |                   |
| 4 | Хууль тогтоомжийн дагуу олгох нөхөн олговор | Эрсдэл гарсан үед өртсөн ажилтнуудад нөхөн олговрыг олгоно. |                              |                |                   |

5.2 2022 оны байдлаар үйлдвэлийн осол огт гараагүй ажилласан бөгөөд ажлын байрны бус эрсдэлд өртсөн нийт 3 ажилтанд хууль тогтоомжийн дагуу Бодь-Даатгалаас 2'436'670 төгрөгийн нөхөн олговор авсан байна.

**6. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

“Ачит-Ихт” ХХК нь МУ-ын хууль, дүрэм журмууд болон олон улсын стандартад нийцсэн компанийн дотоод журмыг боловсруулан хэрэгжүүлэхээс гадна хууль, журмын зүйл заалтын шаардлагын дагуу тухайн жилд хэрэглэсэн Химийн бодисын орлого зарлагын мэдээг тогтмол гаргаж Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлэн ажиллаж байна. Цаашид холбогдох баримт бичгийг боловсруулан мөрдлөг болгон ажиллана.

2022 оны байдлаар төслийн хүрээнд нийт 61 нэр төрлийн химийн бодис хадгалагдан, ашиглагдана. Ашиглагдаж буй химийн бодисууд нь бүгд ХАЛМ-тай бөгөөд цаашид шаардлагад үл нийцэж буй ХАЛМ-тай химийн бодис байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллана.

*Хүснэгт 9. Химийн бодисын менежмент*

| № | Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл        | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ   | Биелэлт   | Хувь |
|---|--|---|---|------|
| 1 | Газар зохион байгуулалт, нүүлгэн шилжүүлэх | “Ачит-Ихт” ХХК-ийн үйлдвэр нь Эрдэнэт үйлдвэрийн эзэмшлийн бүсэд орших бөгөөд үйл ажиллагааны шууд нөлөөлөлд өртөх байнгын оршин суугч байхгүй. | Орхон аймгийн ОБГ-н хянаж баталсан “Химийн хор болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах үеийн ажиллагаатай холбоортой гарч болзошгүй ослын үеийн төлөвлөгөөг” мөрдөж ажиллаж байна. /Хавсралт 14/ | 100  |

|   |  |   |  |            |
|---|--|---|--|------------|
| 2 | Гамшиг ослын эрсдэл  | Гамшиг осол болвол хүн, амьтан, ургамал хордох, эрсдэх, байгаль орчин бохирдох өндөр эрсдэлтэй гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулж штаб, албадыг бэлтгэл сургуулилтаар хангана. | 2022 оны 02-р сард үйлдвэрийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгол хийсэн хувилбарыг Орхон аймгийн ОБГ-н байцаагчаар хянуулж үйлдвэрийн захирлаар батлуулсан. 2022 оны 3р сарын 24нд гамшгийн аюулын дуут дохиогоор ажилласан. Нийт 155 ажилтан хамрагдсан. Цугларалтаар ажилласан тухай тайлан орхон аймгийн ОБГ-т илгээсэн. Гамшгийн дуут дохиогоор ажиллах үед үйлдвэрийн аврах баг хязгаарлагдмал орчноос аврах ажиллагаа явуулах дадлага сургалтыг хийсэн. Үйлдвэрийн гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн гамшгийн үед үүрэг гүйцэтгэх үед шаардлагатай 11ш аранз, аранзад байх шаардлагатай 15 төрлийн эд зүйлсийг бэлдэж бэлэн байдлыг хангаж ажиллаж байна | 100        |
| 3 | Химийн бодисын ашиглалт тогтмол хяналт тавих                               | Ажлын хүрээнд ХБ№1-12 маягтын дагуу бүртгэлийг тогтмол хөтлөх. /ХХБАБТХ-13.7, ХБАЗБХ-13/  | Химийн бодис тээвэрлэх, буулгах үед тусгай зөвшөөрлөөр гүйцэтгэх журмын дагуу тогтмол хяналт тавьж ажиллав.  | 100        |
| 4 | Сургалт  | Химийн бодистой харьцан ажилдаг ажилчдад жил бүр химийн бодисын сургалтанд хамруулах  | Химийн хортой болон аюултай бодистой харьцаж ажиллах аюулгүй ажиллагаа сургалтад 81 ажилчин оролцов. Мөн химийн бодис тээвэрлэх буулгах үед тусгай зөвшөөрлөөр ажил гүйцэтгэх журмыг боловсруулж олгож тогтмол хяналт тавьж ажиллаж байна. Химийн бодисын хэрэглээг тайланг хавсаргав. /Хавсралт 15/   | 100        |
| 5 | Химийн бодистой байнга харьцаж ажилладаг ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх | Ажлын хувцсаар хангах, эрүүл мэндийн үзлэгт жилд 1 удаа хамруулах   | Нэг бүрийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангасан ба өнөөдрийн байдлаар 350сая төгрөгийн хувцас хамгаалах хэрэгсэл худалдаж авсан байна. 2022 онд эрүүл мэндийн үзлэгт нийт 179 ажилтнуудыг 550мянга төгрөгийн багц үзлэгт хамруулсан бөгөөд нийт 98сая төгрөг зарцуулсан байна. ХАБЭА -тай холбоотой зардлууд тусгагдаагүй болно.  | 100        |
|   | <b>Нийт</b>  | <b>1'000'000</b>  | <b>1'000'000</b>   | <b>100</b> |

Химийн бодисыг тээвэрлэх, хадгалах, үйлдвэрлэлд ашиглах үед гэнэтийн ослоос эрсдэл үүсэж химийн бодисоор агаар, гадаргын болон газрын доорх ус, хөрс газрын гадарга бохирдсон тохиолдолд хяналт шинжилгээ хийх, эрсдэлийг арилгах ажлыг Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгаж ажиллаж байна.

## 7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Үйлдвэрийн үйл ажиллагааны үед гарсан хог хаягдал:

- Ахуйн хог хаягдал жилд- 2294 тн
- Аюултай хог хаягдал жилд- 7741 кг

Хүснэгт 10. Хог хаягдлын менежмент

| № | Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ   | Биелэлт   | Хувь |
|---|-------------------------------------|---|---|------|
| 1 | Энгийн хаягдал                      | Орон нутгийн эрх бүхий байгууллагатай хог хаягдлыг устгуулах гэрээ байгуулах, журам, нормативын дагуу төлбөрийг төлөх | Орхон аймгийн хот тохижуулах газартай гэрээ байгуулж ахуйн хог хаягдлыг тогтмол тээвэрлэн хүргэж устгуулж байна. Гэрээг хавсаргав. /Хавсралт-16/  | 100  |
| 2 | Шингэн хаягдал                      | Цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлэлтэд хяналт тавих  | Цэвэрлэх байгууламжийн оролт гаралтын усанд улирал бүр “Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ итгэмжлэгдсэн лабораторид, хагас жилд нэг МХГ-г шинжилгээ хийлгэж хянаж байна. Цэвэрлэх байгууламжаас гарсан усыг 100 хувь эргүүлсэн ашигладаг болно. /Хавсралт 17/  | 100  |
| 3 | Аюултай хаягдал                     | Тусгай эрх бүхий байгууллагад шилжүүлэх, тээвэрлүүлэх, устгуулах  | Үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарсан үйлдвэрийн болон лабораторийн, эмнэлгийн халдвар бүхий аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөл бүхий Цэцүүх трейд ХХК хийсэн гэрээ сунгаж аюултай хог хаягдлыг тээвэрлүүлэн устгуулж байна. Устгуулсан тайлан болон, Аюултай хог хаягдал дагах хуудсыг хавсаргав. /Хавсралт 18/ | 100  |
| 4 | Дахивар хаягдал                     | Дахин боловсруулах хог хаягдлыг ангилан ялгаж эрх бүхий байгууллагад шилжүүлэх  | Картон болон цаасны хаягдлыг “Агдир Бүтэмж” ХХК шилжүүлэхээр хуримтлуулж байна. Артишок-ны лонх “Газар Шим” ХХК-д буцаан өгөхөөр цуглуулж байна.  | 100  |
| 5 | Сургалт                             | Хог хаягдлын ангилан ялгалт, байгаль хамгаалах арга хэмжээний талаар сургалт хийх                                     | Байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO14001:2015 стандарт нэвтрүүлсэнтэй холбоотой “Ахуйн хог хаягдал ангилан ялгах” журмыг дахин танилцуулах сургалт хийж ангилан ялгах боломжоор хангаж нэмэлтээр хогийн сав шинээр байрлуулав.   | 100  |

|            |   |   |   |            |
|------------|---|---|---|------------|
| 6          | Хог хаягдлын тухай мэдээг тогтмол гаргах.   | Энгийн болон аюултай хаягдлын тоо хэмжээ, устгалын тухай мэдээг МХГ, БОАЖГ-т тогтмол хүргүүлэх. | Хагас жилийн хог хаягдлын тайланг БОХЗ маягтын хамтаар Баян-Өндөр сумын байгаль орчны мэргэжилтэнд илгээсэн. Жилийн хог хаягдлын тайлан мэдээг хуулийн хугацаанд зохих журам маягтын дагуу хүргэх болно. /Хавсралт 19/  | 100        |
| 7          | Байгаль хамгаалах хавар, намрын сарын ажлын хүрээнд эзэнгүй дүүргийн хог хаягдлыг БОАЖГ-н өгсөн саналаар цэвэрлэх |   | Хавар БОАЖГ-н саналаар "Эзэнгүй дүүргийн цэвэрлэгээ" Орхон аймгийн Баян-Өндөр сум, Эрдэнэ багийн нутагт 2022 оны 5 дугаар сарын 2-р өдрийн турш 1-г ковш, 2-р хово механизмын бүрэлдэхүүнтэйгээр 216 м3 хог ачив. Мөн Эрдэнэт хотын нэгдсэн хогийн цэг нүүлгэн шилжүүлэх ажилд оролцож 1140м3 хог хаягдлыг ачин тээвэрлэж, 270м3 хар шороог өөрийн байгууллагаас тээвэрлэн буулгаж өгсөн. | 100        |
| <b>Дүн</b> |   | <b>22'000'000</b>   | <b>29'442'000</b>   | <b>100</b> |

## 8. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### 8.1.1 Уурхай, Уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмын дагуу “Хаалт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө”-ний бодлогын баримт бичигтэй болсон байна.

Хаалт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөөтэй болохоор сонгон шалгаруулалт явуулж шалгарсан компанитай гэрээ байгуулсан. Гүйцэтгэгч явцын тайлан ирүүлсэн бөгөөд нийт ажлын гүйцэтгэл 60% тай байна. Гэрээний үнэн дүн 295'900'000 төгрөг

### 8.1.2 Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14001:2015 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, баталгаажуулалтын аудит хийлгэсэн байна.

Байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO 14001:2015 стандартын баталгаажуулалтын аудитыг олон улсын TQCSI компаниар хийлгэж стандартын гэрчилгээ авсан. Гэрээт үнэн дүн 25'944'800 төгрөг

### 8.1.3 Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар Зарлигийн дагуу “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд” 2022-2030 онд 3,0 сая модны тарьц суулгацын нөөцийг бүрдүүлэх зорилгоор мод үржүүлгийн газрын төслийг боловсруулан Орхон аймагт хэрэгжүүлж эхэлнэ.

2022 онд 720сая төгрөгийн хөрөнгө оруулалттайгаар “Далайн Хошууны Шинэс” нэртэй мод үржүүлгийн газар байгуулж 460мянган үрсэлгээ үрслүүлэв.

### 8.1.4 Байгаль орчны төлөвлөгөөт аудит



Сонгон шалгаруулалт явуулж “Ногоон Гэрэлт Ирээдүй” ХХК шалгарсан бөгөөд гэрээ байгуулж ажил эхэлсэн. Гэрээт үнэн дүн 14’550’000 төгрөг

## 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

“Ачит-Ихт” ХХК-ийн катодын зэс үйлдвэрлэх төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх, үүссэн нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг бодит судалгаа, шинжилгээнд үндэслэн хэрэгжүүлж байна.

“Ачит-Ихт” ХХК орчны хяналт шинжилгээг “Агаар, гүний ус, хөрс”-нд Орхон аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний албатай хамтран хийж байна. Байгаль орчны аудитын зөвлөмжийн дагуу хөрсний дээжээс хүнд металлыг SGS лабораторид судлуулахаар төсөвлөсөн байна. Мөн өөрийн лабораторид хуваарийн дагуу тогтмол дээж авч шинжлэн, хяналт тавин ажиллаж байна.

Хүснэгт 11. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

| №   | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд  | Төлөвлөгөө   | Биелэлт  | Хувь |
|---|--|--|--|------|
| 1. Агаарын бохирдлыг хянах, бууруулах асуудлаар |  |  |  |      |
| 1   | NO2                      SO2   | Үйлдвэрийн 6 цэгээс агаарын хяналт хийх. улиралд 1, жилд 24 шинжилгээ  | Хуваарийн дагуу улиралд нэг удаа аймгийн УЦУОШТ-с дээж авч шинжилгээ хийсэн. MNS4585:2016 стандартын ЗДХ давсан тохиолдол байхгүй. | 100  |
| 2   | Агаар орчныг бохирдуулагч элементийн хяналт шинжилгээ хийлгэх                        | Уурын зуухны яндангаас гарах утаанд шинжилгээ хийх байгууллагыг сонгох | Азотын давхар исэл, хүхэрлэг хий, тоосны шинжилгээ хийлгэсэн. MNS4585:2016 стандартын дахь хүлцэх агууламжаас даваагүй байна.      | 100  |
| 3   | Цаг уур: агаарын хэм, салхины хурд, харьцангуй чийг, даралт хэмжилтийг тогтмол хийх. |  | Сар бүрийн нэгэнд тогтмол мэдээ УЦУОШТ-с авсан.  | 100  |
| 4   | Орчны агаар дахь тоосжилтын хэмжилт шинжилгээг хийлгэх. (Нийт тоос, Pm 2.5, Pm10)    |  | Консалтингийн байгууллагаар 5 цэгээс шинжилгээ хийлгэсэн.  | 100  |
| 2. Хөрсний бүхэвч, газар ашиглалт               |  |  |  |      |

|  |  |  |  |     |
|--|--|--|--|-----|
| 5  | Хөрсний бүрхэвчийн хяналтын цэгүүдээс дээж авч шинжлүүлэх<br>Тодорхойлох элемент: PH, NH <sub>4</sub> , SO <sub>4</sub> , Fe, PO | Үйлдвэрийн хөрсөн бүрхэвчийн хяналтын 5 цэгээс жилд 2-р удаа дээж авч шинжилгээ хийлгэх. | УЦУОШТ хөрсний дээжлэлт хийсэн.  | 100 |
| 6  | Элемент тодорхойлох: Cu, Mo, Cd, Zn, As, Pb, Cr, Ni  |  | 5 цэгээс хүнд элемент дээж авч хөрсний итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.                              | 100 |
| <b>3. Гадаргын болон газрын доорх ус</b> |  |  |  |     |
| 7  | Гүний усны хяналтын цооногуудаас дээж авч хяналт тавих Тодорхойлох элемент: рН, SO <sub>4</sub> , ЖБ                             | Гүний усны хяналтын 10 цооногоос сар бүр дээж авч хянах.                                 | Сар бүр аймгийн УЦУОШТ-с гэрээний дагуу ус агуулсан 8-н цооногоос дээжлэлт хийж 96 сорьц шинжилгээ хийсэн. | 100 |
| 8  | Элемент тодорхойлох: Mo, Cd, Zn, As, Pb, Cr, Ni, Cu  |  | 8 цэгээс дээж авч SGS лабораторид шинжлүүлсэн.   | 100 |
| <b>4. Бусад</b>                          |  |  |  |     |
| 9  | Мониторингийн тайланг улирал тутамд БОАЖГ болон Сумын засаг даргын дэргэдэх БО хариуцсан мэргэжилтэнд хүргүүлэх.                 |  | Баян-Өндөр сумын БО хариуцсан мэргэжилтэнд мэдээ хүргүүлсэн  | 100 |
|  | <b>Дүн</b>   | <b>10,240,000</b>  | <b>7,880,000</b>   | 100 |

## 10. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

“Ачит-Ихт” ХХК-ийн катодын зэс үйлдвэрлэх төсөл “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын үйлдвэрийн бүсэд орших бөгөөд энэ бүсэд байнгын оршин суугч байхгүй хэдий ч Байгаль хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажлууд түүн дотроо орчны хяналт шинжилгээний хөтөлбөр болон нөхөн сэргээлтийн ажлыг тогтмол хэрэгжүүлэхийн ач холбогдол, үр дүнг хэрхэн сум, багийн иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэх арга замын талаар орон нутгийн хэлтэстэй ярилцан оновчтой арга хэлбэрийг сонгон хэрэгжүүлнэ.


*Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь*

| № | БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд    | Биелэлт  | Хувь |
|---|--|--|------|
| 1 | Үйлдвэрийн удирдлагад                              | Сар улирал тайлагнав                                   | 100  |
| 2 | Компанийн хэмжээнд мэдээлэл, танилцуулга хийх      | Хагас жил, жилийн эцэст тайлан бичнэ.                  | 100  |
| 3 | Баян-цагаан багийн Оршин суугчдад танилцуулах      | 11 дүгээр сарын 9-д танилцуулсан хурлын ирц хавсаргав. | 100  |
| 4 | Орон нутгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт | БОМТ биелэлт тайлагнах                                 | 100  |
| 5 | Аймгийн Мэргэжлийн хяналтын газарт                 | Газар дээрх шалгалт хийсэн.                            | 100  |
| 6 | Эрх бүхий байгууллагад тайлангаа хүргүүлэх         | Тогтсон хугацаанд                                      | 100  |
|   | Нийт   |  | 100  |

**XABCRAJT**

**УС ЦАГ УУР, ОРЧНЫ  
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ**

Сүхбаатар сум, Цагаан эрэгийн гудамж,  
2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036-3983



**БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН**

Дугаар он 2022 /A118-122

Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас

Дээжийн тодорхойлолт

Дээж авсан хүний нэр, албан тушаал

Дээжийн тоо, төрөл

Хүлээн авсан огноо

Сорилтын арга, аргачлал

Дээжийн тодорхойлсон үзүүлэлт

Шинжилгээ хийж дууссан огноо

“Терра Натур Консалтинг” ХХК-ны захиалга

Эрдэнэт хот, “Ачит Ихт” ХХК-ны үйлдвэр

БОШЛ-ийн ерөнхий инженер М.Аягүл

1, Агаарын дээж

2022 - 11 - 01

MNS17.2.5.12:88, MNS17.2.5.11:88, MNS4048-88

хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоос

2022 - 11 - 02

**АГААРЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**

| №  | Хэмжилт хийсэн цэгийн нэр     | Тодорхойлсон элементүүд, мг/м3        |                                 |              |              |            |
|--|-------------------------------|---------------------------------------|---------------------------------|--------------|--------------|------------|
|  |                               | Азотын давхар исэл (NO <sub>2</sub> ) | Хүхэрлэг хий (SO <sub>2</sub> ) | Тоос (нийт)  |              |            |
|  |                               |                                       |                                 | Дундаж       | Хамгийн бага | Хамгийн их |
| 1  | Үйлдвэрийн уурын зуухны орчим | 0.018                                 | 0.002                           | 0.000        | 0.000        | 0.000      |
| 2  | Баяжуулах үйлдвэр             | 0.023                                 | 0.002                           | 0.001        | 0.000        | 0.139      |
| 3  | Овоолго доод PLS цөөрөм       | 0.041                                 | 0.029                           | 0.007        | 0.000        | 0.034      |
| 4  | Овоолго дээд                  | 0.029                                 | 0.002                           | 0.033        | 0.007        | 0.058      |
| 5  | Авто зогсоол                  | 0.041                                 | 0.005                           | 0.028        | 0.004        | 0.379      |
| MNS4585:2016 стандарт дахь хүлцэх агууламж |                               | <b>0.200</b>                          | <b>0.450</b>                    | <b>0.500</b> |              |            |

Дүгнэлт:

Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт байрлах “Ачит Ихт” ХХК-ны орчмоос агаарын дээж авч химийн шинжилгээ хийж үзэхэд MNS 4585:2016 стандарт дахь хүлцэх агууламжаас даваагүй байна.

Шинжилгээ хийсэн БОШЛ-ийн инженер

Шинжилгээг хянасан: БОШЛ-ийн ерөнхий инженер

Т.Цэрэндолгор


М.Аягүл



Хуулбарлан хэвлэхийг хориглоно.

Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

00014



ХӨРС СУДЛАЛЫН  
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК

Дугаар: 22/1415

Утас/Факс 77278899, 77288899

E-mail: soil\_lab@g-mongol.mn

Дээж авсан огноо: 2022 он 04 сарын 25

Шинжилгээ хийсэн огноо: 2022 он 04 сарын 26-27

Дээж авсан газрын нэр: Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянцагаан баг, Үйлдвэрийн бүс

Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "Ачит-Ихт" ХХК

Харилцах утас: 95768633

Хөрсний хүнд металл

| №   | Лаб №   | Дээжний нэр                                  | Гүн,<br>см | Хүнд металл мг/кг |               |                     |          |              |              |
|---|---------|--|------------|-------------------|---------------|---------------------|----------|--------------|--------------|
|   |         |  |            | Ni<br>/Никель/    | Cd<br>/Кадми/ | Pb /Хар<br>тугалга/ | Cu /Зэс/ | Zn<br>/Цайр/ | Cr<br>/Хром/ |
| 1   | 22/2711 | S1 2-р овоолгын доор                         | -          | 54.1              | 2.97          | 218.6               | 18.7     | 189.2        | 10.2         |
| 2   | 22/2712 | S2 Бодисын агуулахын дэргэд /Хүчлийн агуулах | -          | 33.7              | 0.01          | 23.0                | 44.6     | 121.3        | 17.3         |
| 3   | 22/2713 | S3 Хог хаягдлын ойр орчим                    | -          | 39.9              | ND            | 18.7                | 45.6     | 95.2         | 11.7         |
| 4   | 22/2714 | S4 Уурын зуух                                | -          | 42.5              | ND            | 18.0                | 51.3     | 101.2        | 12.6         |
| 5   | 22/2715 | S5 Үйлдвэрийн ойр орчим                      | -          | 41.8              | ND            | 19.0                | 50.9     | 136.8        | 7.47         |
| Хүлцэх агууламж /MNS 5850:2019/                 |         |  |            | 150,0             | 3,0           | 100,0               | 100,0    | 300,0        | 150,0        |
| Хортой агууламж /MNS 5850:2019/                 |         |  |            | 1000,0            | 10,0          | 500,0               | 500,0    | 600,0        | 400,0        |
| Аюултай агууламж /MNS 5850:2019/                |         |  |            | 1800,0            | 20,0          | 1200,0              | 1000,0   | 1000,0       | 1500,0       |
| Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт |         |  |            | /MNS 5850:2019/   |               |                     |          |              |              |

\*ND-not detect

Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.

Шинжилгээ хийсэн арга стандарт:

(MNS ISO 11466:2007)

Лабораторын эрхлэгч:

Л. Цагаандархи /MS.c/-z

Задлан шинжээч:

Х. Жаргалмаа







№ 08

УС ЦАГ УУР ОРЧНЫ  
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ЛАБОРАТОРИ

Орхон аймаг, Баянцагаан баг,  
Тосгон Утас/Факс: 70357258  
E-mail: orkhon@namem.gov.mn

СОРИЛТЫН ЛАБОРАТОРИЙН ТАЙЛАН

Дугаар он/№ : 2022.01  
Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : Ачит Ихт ХХК  
Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал : Б.Орхонтамир /техникч/  
Сорьцын тоо, төрөл : 8, ус  
Сорьц авсан огноо : 2022.01.26  
Шинжилгээний дүн өгсөн огноо : 2022.02.22  
Сорьцын тодорхойлолт : Хяналтын цооног сорьц  
Шинжилгээний аргын стандарт : MNS ISO 10523:2001 MNS 6271:2011  
MNS ISO 11923:2001  
Шинжилсэн огноо : 2022.01.26-28  
Хуудасны тоо : 1/1

| Цэгийн нэр            | pH      | SO <sub>4</sub> мг/л | Ж.б мг/л |
|-----------------------|---------|----------------------|----------|
| PLS                   | 6.86    | 762.1                | 30.6     |
| SX                    | 6.90    | 1125.5               | 32.2     |
| I Цооног-30           | 7.28    | 136.5                | 17.6     |
| II Цооног-30          | 7.68    | 120.0                | 2.6      |
| Цооног – 100.000м-II  | 7.34    | 90.4                 | 43.2     |
| Цооног-100.000м-III   | 7.58    | 46.5                 | 24.2     |
| Цооног-10 Н/У         | 7.32    | 272.4                | 52.2     |
| Raff                  | 7.23    | 379.5                | 6.8      |
| Стандарт MNS6148:2010 | 6.5-8.5 | 500.0                | -        |

Тайлбар: Ж/б-Жинлэгдсэн бодис

Шинжилгээ гүйцэтгэсэн Ус, хөрсний инженер: Г.Жаргалсайхан  
Техникч: Н.Энхмаа

Хянасан: БО-ны хяналтын улсын ахлах байцаагч: Д. Сүхбат

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын үр дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.



№ 11

УС ЦАГ УУР ОРЧНЫ  
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ЛАБОРАТОРИ

Орхон аймаг, Баянцагаан баг,  
Тосгон Утас/Факс: 70357258  
E-mail:orkhon@namem.gov.mn

СОРИЛТЫН ЛАБОРАТОРИЙН ТАЙЛАН

Дугаар он/№ : 2022.02  
Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : Ачит Ихт ХХК  
Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал : Н.Энхмаа /техникч/  
Сорьцын тоо, төрөл : 8, ус  
Сорьц авсан огноо : 2022.02.23  
Шинжилгээний дүн өгсөн огноо : 2022.03.14  
Сорьцын тодорхойлолт : Хяналтын цооног сорьц  
Шинжилгээний аргын стандарт : MNS ISO 10523:2001 MNS 6271:2011  
MNS ISO 11923:2001  
Шинжилсэн огноо : 2022.02.23-25  
Хуудасны тоо : 1/1

| Цэгийн нэр                   | pH             | SO <sub>4</sub> мг/л | Ж.б мг/л |
|------------------------------|----------------|----------------------|----------|
| PLS                          | 6.48           | 801.3                | 26.0     |
| SX                           | 6.83           | 1565.2               | 47.0     |
| I Цооног-30                  | 7.57           | 138.7                | 53.8     |
| II Цооног-30                 | 8.00           | 123.0                | 28.0     |
| Цооног – 100.000м-II         | 7.57           | 85.9                 | 60.4     |
| Цооног-100.000м-III          | 7.94           | 62.3                 | 71.6     |
| Цооног-10 Н/У                | 7.58           | 283.5                | 20.8     |
| Raff                         | 7.63           | 376.1                | 56.4     |
| <b>Стандарт MNS6148:2010</b> | <b>6.5-8.5</b> | <b>500.0</b>         | -        |

Тайлбар: Ж/б-Жинлэгдсэн бодис

Шинжилгээ гүйцэтгэсэн Ус, хөрсний инженер: Г.Жаргалсайхан  
Техникч: Б.Орхонтамир

Хянасан: БО-ны хяналтын улсын ахлах байцаагч: Д.Сүхбат

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын үр дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.



№ 10

УС ЦАГ УУР ОРЧНЫ  
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ЛАБОРАТОРИ

Орхон аймаг, Баянцагаан баг,  
Тосгон Утас/Факс: 70357258  
E-mail: orkhon@namem.gov.mn

СОРИЛТЫН ЛАБОРАТОРИЙН ТАЙЛАН

Дугаар он/№ : 2022.03  
Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : Ачит Ихт ХХК  
Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал : Б. Орхонтамир /техникч/  
Сорьцын тоо, төрөл : 8, ус  
Сорьц авсан огноо : 2022.03.22  
Шинжилгээний дүн өгсөн огноо : 2022.04.19  
Сорьцын тодорхойлолт : Хяналтын цооног сорьц  
Шинжилгээний аргын стандарт : MNS ISO 10523:2001 MNS 6271:2011  
MNS ISO 11923:2001  
Шинжилсэн огноо : 2022.03.23-25  
Хуудасны тоо : 1/1

| Цэгийн нэр            | pH      | SO <sub>4</sub> мг/л | Ж.б мг/л |
|-----------------------|---------|----------------------|----------|
| PLS                   | 6.65    | 595.9                | 19.8     |
| SX                    | 7.10    | 887.2                | 35.4     |
| I Цооног-30           | 7.99    | 93.5                 | 17.2     |
| II Цооног-30          | 7.65    | 69.8                 | 41.6     |
| Цооног – 100.000м-II  | 8.03    | 30.4                 | 26.4     |
| Цооног-100.000м-III   | 7.50    | 202.3                | 43.8     |
| Цооног-10 Н/У         | 7.71    | 257.8                | 253      |
| Raff                  | 7.68    | 149.5                | 33.4     |
| Стандарт MNS6148:2010 | 6.5-8.5 | 500.0                | -        |

Тайлбар: Ж/б-Жинлэгдсэн бодис

Шинжилгээ гүйцэтгэсэн Ус, хөрсний инженер: Г.Жаргалсайхан  
Техникч: Б.Орхонтамир

Хянасан: БО-ны хяналтын улсын ахлах байцаагч: Д. Сүхбат

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын үр дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.



№ 18

УС ЦАГ УУР ОРЧНЫ  
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ЛАБОРАТОРИ

Орхон аймаг, Баянцагаан баг,  
Тосгон Утас/Факс: 70357258  
E-mail:orkhon@namem.gov.mn

СОРИЛТЫН ЛАБОРАТОРИЙН ТАЙЛАН

Дугаар он/№ : 2022.03  
Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : Ачит Ихт ХХК  
Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал : Б. Орхонтамир /техникч/  
Сорьцын тоо, төрөл : 6, агаар  
Сорьц авсан огноо : 2022.03.22  
Шинжилгээний дүн өгсөн огноо : 2022.04.19  
Сорьцын тодорхойлолт : Агаарын шинжилгээний сорьц  
Шинжилгээний аргын стандарт : MNS 17.2.5 12:88 MNS17.2.5 11:88  
Шинжилсэн огноо : 2022.03.23  
Хуудасны тоо : 1/1

| Цэгийн нэр                   | NO <sub>2</sub> мг/м <sup>3</sup> | SO <sub>2</sub> мг/м <sup>3</sup> |
|------------------------------|-----------------------------------|-----------------------------------|
| PLS                          | 0.024                             | 0.027                             |
| SX цех                       | 0.046                             | 0.026                             |
| Харуулын байр                | 0.041                             | 0.021                             |
| Уусгалтын талбай             | 0.024                             | 0.003                             |
| Уурын зуух                   | 0.036                             | 0.054                             |
| Хүчлийн агуулах              | 0.022                             | 0.007                             |
| <b>Стандарт MNS4585:2016</b> | <b>0.200</b>                      | <b>0.450</b>                      |

Шинжилгээ гүйцэтгэсэн техникч:  
Хянасан инжөнөр:

Б.Орхонтамир  
Г.Жаргалсайхан

Хянасан: БО-ны хяналтын улсын ахлах байцаагч: Д. Сүхбат

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын үр дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.



№ 23

УС ЦАГ УУР ОРЧНЫ  
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ЛАБОРАТОРИ

Орхон аймаг, Баянцагаан баг,  
Тосгон Утас/Факс: 70357258  
E-mail:orkhon@namem.gov.mn

СОРИЛТЫН ЛАБОРАТОРИЙН ТАЙЛАН

Дугаар он/№ : 2022.04  
Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : Ачит Ихт ХХК  
Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал : Н.Энхмаа /техникч/  
Сорьцын тоо, төрөл : 8, ус  
Сорьц авсан огноо : 2022.04.20  
Шинжилгээний дүн өгсөн огноо : 2022.05.25  
Сорьцын тодорхойлолт : Хяналтын цооног сорьц  
Шинжилгээний аргын стандарт : MNS ISO 10523:2001 MNS 6271:2011  
MNS ISO 11923:2001  
Шинжилсэн огноо : 2022.04.20-22  
Хуудасны тоо : 1/1

|                                 | MNS ISO 5815:2001                                 | Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч                                | 400 мгО/л                             | 113 мгО/л                       |
|                                 | MNS ISO 10523:2001                                | pH   | 6.0-9.0                               | 7.8                             |
|                                 | MNS ISO 11923:2001                                | Умбуур бодис   | 400 мг/л                              | 189 мг/л                        |
|                                 | MNS ISO 6060:2001                                 | Химийн хэрэгцээт хүчилтөрөгч                                   | 800 мгО/л                             | 334 мгО/л                       |
| 437                             | MNS 1097:1970                                     | Өнгө ба тунгалаг чанар   |                                       | 15.5 см                         |
|                                 | MNS 5668-2003                                     | Эмгэгтөрөгч нян  | 1мл-т илрэхгүй                        | Илрээгүй                        |
|                                 | CA3 A-03  | Аммони   | 6 мг/л                                | 21.4 мг/л                       |
|                                 | MNS ISO 5815:2001                                 | Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч                                | 20 мгО/л                              | 20 мгО/л                        |
|                                 | MNS ISO 10523:2001                                | pH   | 6.0-9.0                               | 7.7                             |
|                                 | MNS ISO 11923:2001                                | Умбуур бодис   | 50 мг/л                               | 66 мг/л                         |
| MNS ISO 6060:2001               | Химийн хэрэгцээт хүчилтөрөгч                      | 50 мгО/л   | 45.6 мгО/л                            |                                 |
| MNS 1097:1970                   | Өнгө ба тунгалаг чанар                            |  |                                       | 14.8 см                         |

### Санал тайлбар:

*Opinions and interpretation*

БАТАЛСАН: ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ:


*Approved by*



/Б.ЭНХТАЙВАН/

Энэ шинжилгээний дүн нь зөвхөн шинжилгээ хийсэн дээжинд хамаарна.  
Шинжилгээний дүнг лабораторийн зөвшөөрөлгүй хуулбарлахыг хориглоно.





МХЕГ-ын Хүнсний Аюулгүй Байдлын Үндэсний лавлагаа лабораторийн  
Ерөнхий захирлын 2018 оны 05 сарын 09-ний өдрийн А/20 дугаар  
тушаалын хавсралт  
Маягт 01-65

**ОРХОН АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН  
ГАЗРЫН ИТГЭМЖЛЭГДСЭН СОРИЛТЫН ЛАБОРАТОРИ**

Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уурхайчин баг.

Утас: [70357914](tel:70357914)

**ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН  
CERTIFICATE OF ANALYSIS**

Бүртгэлийн дугаар /Registration number/: 22-776

Шинжилгээ хийлгэх хүсэлт гаргасан газрын нэр : Ачит Ихт ХХК

(The name of customer's request for analysis)

Дэд лабораторийн нэр /Name of the sub laboratory/: Эрүүл ахуйн нян судлалын хяналтын лаборатори; Эрүүл ахуйн хими, хор судлалын хяналтын лаборатори

| Дээжийн тодорхойлолт /Sample description |                               |                                 |  |   |  |
|--|-------------------------------|---------------------------------|--|---|--|
| Дээжийн дугаар<br>Sample number          | Дээжийн нэр<br>Name of sample | Цувралын дугаар<br>Batch number | Үйлдвэрлэсэн улс<br>The country of original manufacturer | Бүтээгдэхүүний хүчинтэй хугацаа<br>Date of expiry | Дээжийн тоо хэмжээ<br>Quantity of the sample |
| 2420                                     | Бохир ус- оролт               | -                               | Монгол Улс   | Тодорхойгүй                                       | 1.25 л                                       |
| 2421                                     | Бохир ус- гаралт              | -                               | Монгол Улс   | Тодорхойгүй                                       | 1.25 л                                       |

| Хүлээн авсан огноо<br>Date of receipt | Шинжилгээ дууссан огноо<br>Date of test completion | Хэвлэсэн огноо<br>Date of issue of the report |
|---------------------------------------|--|---|
| 2022 он 10 сар 03 өдөр                | 2022 он 10 сар 12 өдөр                             | 2022 он 10 сар 12 өдөр                        |

| Дээжийн дугаар<br>Sample number | Шинжилгээний аргын стандарт<br>Method of analysis | Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж<br>Test parameter, unit | Шаардлага<br>Test specification, unit | Шинжилгээний дүн<br>Test results |
|---------------------------------|---|--|---------------------------------------|----------------------------------|
| 2420                            | MNS 5668:2003                                     | Гэдэсний бүлгийн нян   |                                       | Е.Coli илрэв                     |
|                                 | CA3 A-03  | Аммони   | 15 мг/л                               | 68 мг/л                          |
|                                 | MNS ISO 5815:2001                                 | Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч                                | 400 мгО/л                             | 450 мгО/л                        |
|                                 | MNS ISO 10523:2001                                | pH   | 6.0-9.0                               | 6.9                              |
|                                 | MNS ISO 11923:2001                                | Умбуур бодис   | 400 мг/л                              | 805 мг/л                         |
|                                 | MNS ISO 6060:2001                                 | Химийн хэрэгцээт хүчилтөрөгч                                   | 800 мгО/л                             | 456 мгО/л                        |
| 2421                            | MNS 1097:1970                                     | Өнгө ба тунгалаг чанар   | -                                     | 2 см                             |
|                                 | MNS 5668:2003                                     | Гэдэсний бүлгийн нян   | 1мл-т илрэхгүй                        | Е.Coli илрэв                     |
|                                 | CA3 A-03  | Аммони   | -                                     | 31 мг/л                          |
|                                 | MNS ISO 5815:2001                                 | Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч                                | 20 мгО/л                              | 11.3 мгО/л                       |
|                                 | MNS ISO 10523:2001                                | pH   | 6.0-9.0                               | 8.0                              |
|                                 | MNS ISO 11923:2001                                | Умбуур бодис   | 50 мг/л                               | 159 мг/л                         |
| MNS ISO 6060:2001               | Химийн хэрэгцээт хүчилтөрөгч                      | 50 мгО/л   | 61 мгО/л                              |                                  |
| MNS 1097:1970                   | Өнгө ба тунгалаг чанар                            | -  | 19 см                                 |                                  |

**Санал тайлбар:**

Opinions and interpretation

**БАТАЛСАН: ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ:**


Approved by



/Б.ЭНХТАЙВАН/

Энэ шинжилгээний дүн нь зөвхөн шинжилгээ хийсэн дээжинд хамаарна.  
Шинжилгээний дүнг лабораторийн зөвшөөрөлгүй хуулбарлахыг хориглоно.





**АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, УСТГАХ  
ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ АЖ АХУЙН НЭГЖИД ХАЯГДАЛ  
ШИЛЖҮҮЛЭН ӨГӨХ ГЭРЭЭ**  
№ 22/406 - А

Энэхүү Ажил гүйцэтгэх гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г

**НЭГ ТАЛААС 4388054** тоот регистрийн дугаартай, Монгол Улс, Орхон аймаг, 15 дугаар хороо, Баян-Өндөр сум, Малчин баг, Нарийн хөндий 3 замын уулзвар “Монпители Ойл” ХХК-ийн үйлдвэрийн байр хаягт орших “Монпители Ойл” ХХК (цаашид “Шилжүүлэн авагч” гэх)-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Наранхүү,

**НӨГӨӨ ТАЛААС 2788705** тоот регистрийн дугаартай, Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Стадион оргил-1, Чингисийн өргөн чөлөө-6, Кэй Би тауэр, 21 давхар хаягт орших “Ачит-Ихт” ХХК (цаашид “Шилжүүлэгч” гэх)-ийг төлөөлж Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны менежер Ж.Мөнхдархан нар (цаашид тус тусад нь “Тал”, хамтад нь “Талууд” гэх) Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, Хог хаягдлын тухай хууль, Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтаар батлагдсан Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журмыг тус тус үндэслэн дараах нөхцөлийг харилцан тохиролцооноор байгуулав.

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Энэхүү Гэрээгээр Монгол улсын Хог хаягдлын тухай хуулийн 8.1.4 дэх хэсэгт заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас тусгай зөвшөөрөл авсан Шилжүүлэн авагч нь *Захиалагчийн катодын зэсийн үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, багасгах, ангилах, ялгах, дахин ашиглах, боловсруулах, устгах, хог хаягдлын менежментийн шатлалыг бий болгох, шилжүүлэн авах ажил* (цаашид “Ажил” гэх)-ыг батлагдсан ажлын даалгавар, төсөвт нийцүүлэн холбогдох хууль, дүрэм, журам, стандарт, норм, нормативын дагуу гэрээний хугацаанд чанартай, мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэн, ажлын үр дүнг Шилжүүлэгчид тайлагнах (цаашид “Ажлын үр дүн” гэх), Шилжүүлэгч нь түүнд тохирсон төлбөрийг төлөхтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. Дор дурдсан баримт бичгүүд нь Гэрээний бүрдэл хэсэг болно.
  - (а) Хавсралт 1: Аюултай хог хаягдлыг дагалдах бичиг (маягт)
  - (б) Хавсралт 2: Тусгай зөвшөөрөл
- 1.3. Шилжүүлэгч нь үйлдвэрийн үйл ажиллагааны явцад үүссэн бүх төрлийн ашиглалтаас гарсан тос, масло, хаягдал дугуй зэрэг аюултай хог хаягдлыг нэр төрөл тоо хэмжээний дагуу Шилжүүлэн авагчийн өмчлөлд шилжүүлэх, шилжүүлэн авагч нь шилжүүлэн авсан аюултай хог хаягдлыг холбогдох хууль тогтоомж эрх зүйн актын дагуу шийдвэрлэнэ.
- 1.4. Шилжүүлэгчээс шилжүүлэн авагчид аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгөх бүрд Хавсралт 1-д заасан дагалдах бичгийг үйлдэж гэрээнд хавсаргана.
- 1.5. Энэхүү гэрээний хугацаа нь 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийг хүртэл 2 жилийн хугацаатай байна.
- 1.6. Гүйцэтгэгч нь ажлыг хийж гүйцэтгэхдээ үйлдвэрлэлийн болон ажил гүйцэтгэж байгаа бусад этгээдийн хэвийн үйл ажиллагаанд аль болох саад учруулахгүйгээр зохион байгуулна.
- 1.7. Ажлын байр, талбайд Захиалагчийн дотоод болон аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг мөрдөж ажиллах, орон нутгийн байгууллага, оршин суугчдад хүндэтгэлтэй хандах үүрэгтэй.
- 1.8. Гэрээгээр хүлээсэн үүргээ талууд бүрэн биелүүлж, бие биеэ харилцан хүндэтгэх зарчмыг баримтлан ажиллана.
- 1.9. Гэрээнд хэрэглэгдэх нэр томъёог дараах утгаар ойлгоно.
  - 1.9.1. “Гэрээ” гэж Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулсан Ажил гүйцэтгэх гэрээ болон гэрээний хавсралтуудыг;
  - 1.9.2. “Эрх бүхий албан тушаалтан” гэж гэрээ, хэлцэл байгуулахад шууд болон шууд бусаар оролцож буй гэрээ батлах болон гэрээ байгуулахаар гарын үсэг зурах эрх олгогдсон этгээдийг;

|            |                         |                 |              |
|------------|-------------------------|-----------------|--------------|
| Огноо      | Талууд гарын үсэг зурах |                 | Хуудас 1 / 8 |
| 2022-10-24 | Шилжүүлэгч              | Шилжүүлэн авагч |              |



БАТЛАВ:  
“АЧИТ-ИХТ” ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Д.ЭРДЭНЭЦЭЦГ



ОГНОО: / 2022.11.01 /

БАТЛАВ:  
“НОГООН ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙ”  
ХХК-ИЙН ЗАХИРАЛ  
Д.БАТБОЛД



ОГНОО: / 2022.11.01 /



АСНIT IKHT LLC

2022 оны 11 дүгээр  
сарын 01-ний өдөр

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ  
/Байгаль орчны аудит хийх/

№ 22/416 - А

Улаанбаатар  
хот

Энэхүү Ажил гүйцэтгэх гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г НЭГ ТАЛААС 5725011 тоот регистрийн дугаартай, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 9 дүгээр хороо, Их тойруу-70, Мөнх-Хүдэр оффис, 3 давхарт 301 тоот хаягт орших “Ногоон гэрэлт ирээдүй” ХХК (цаашид “Гүйцэтгэгч” гэх) түүнийг төлөөлж захирал Д.Батболд,

НӨГӨӨ ТАЛААС 2788705 тоот регистрийн дугаартай, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Стадион оргил-1 Чингисийн өргөн чөлөө-6, Кэй Би тауэр, 21 давхар хаягт оршдог “Ачит-Ихт” ХХК (цаашид “Захиалагч” гэх)-ийг төлөөлж Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны менежер Ж.Мөнхдархан нар (цаашид тус тусад нь “Тал”, хамтад нь “Талууд” гэх) Иргэний хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад хууль тогтоомжийг үндэслэн дараах нөхцөлийг харилцан тохиролцсоноор байгуулав.

### НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь *Захиалагчийн Орхон аймагт байрлах, катодын зэсийн үйлдвэрийн үйл ажиллагаанд байгаль орчны аудит хийх ажил* (цаашид “Ажил” гэх)-ыг батлагдсан ажлын даалгавар, төсвийн дагуу, холбогдох хууль, дүрэм, журам, стандарт, норм, нормативын дагуу гэрээний хугацаанд чанартай, мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэн ажлын үр дүнг тайлангаар хүлээлгэн өгөх /цаашид “Ажлын үр дүнг” гэх/, Захиалагч нь түүнд тохирсон хөлсийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. Дор дурдсан баримт бичгүүд нь Гэрээний бүрдэл хэсэг болно.
  - (а) Хавсралт 1: Ажлын даалгавар;
  - (б) Хавсралт 2: Нууцлал хадгалах гэрээ;
  - (в) Хавсралт 3: Ажлын үр дүнг хүлээн авах акт;
- 1.3. Гүйцэтгэгчээс ажлыг бүрэн хийж гүйцэтгэн Захиалагчид үр дүнг хүлээлгэн өгөх эцсийн хугацаа 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдөр байна.
- 1.4. Гэрээний нийт үнэ нь 14,550,000.00 (*арван дөрвөн сая таван зуун тавин мянган*) төгрөг бөгөөд холбогдох зардал, томилолтын зардал болон бүх татвар, суутгал НӨАТ багтсан болно. Гэрээт хугацаанд талууд гэрээний үнэд өөрчлөлт оруулахгүй болно.
- 1.5. Талууд Гэрээнд заасан үүргийг зохих ёсоор хугацаанд нь гүйцэтгэснээр гэрээний харилцаа дуусгавар болно.
- 1.6. Гүйцэтгэгч нь Гэрээгээр хүлээсэн үүргээ Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй, дамжуулахгүй, давхар гэрээлэхгүй байх үүрэгтэй ба гэрээ байгуулах шаардлагатай тохиолдолд урьдчилан Захиалагчаас бичгээр зөвшөөрөл авна.
- 1.7. Гүйцэтгэгч нь ажлыг хийж гүйцэтгэхдээ үйлдвэрлэлийн болон ажил гүйцэтгэж байгаа бусад этгээдийн хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр зохион байгуулна.
- 1.8. Ажлын байр талбайд Захиалагчийн дотоод болон аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг мөрдөж ажиллах, орон нутгийн байгууллага, оршин суугчдад хүндэтгэлтэй хандах үүрэгтэй.
- 1.9. Гэрээнд хэрэглэгдэх нэр томъёог дараах утгаар ойлгоно.
  - 1.9.1. “Гэрээ” гэж Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулсан Ажил гүйцэтгэх гэрээ болон гэрээний хавсралтуудыг ойлгоно.
  - 1.9.2. “Эрх бүхий албан тушаалтан” гэж гэрээ, хэлцэл байгуулахад шууд болон шууд бусаар оролцож буй гэрээ батлах болон гэрээ байгуулахаар гарын үсэг зурах эрх олгогдсон этгээдийг,

| Огноо      | Талууд гарын үсэг зурах |            | Хуудас 1 / 11 |
|------------|-------------------------|------------|---------------|
| 2022-11-01 | Захиалагч               | Гүйцэтгэгч |               |



БАТЛАВ:  
“АЧИТ-ИХТ” ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Д.ЭРДЭНЭЦЭЦЭГ



ОГНОО: / 2022.02.22



БАТЛАВ:  
ОРХОН АЙМГИЙН ХОТ  
ТОХИЖУУЛАХ ГАЗРЫН ДАРГА  
Б.ОЮУНБАЯР



ОГНОО: / 2022.03.01



### ХОГ ХАЯГДАЛ УСТГАХ ГЭРЭЭ

№ 22/099-А

2022 оны 02 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү Хог хаягдал устгах гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г **НЭГ ТАЛААС** 2101017 тоот регистрийн дугаартай, Монгол Улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянцагаан баг, Өөрийн байр, Хот тохижуулах газар (цаашид “Гүйцэтгэгч” гэх)-ыг төлөөлж Хот тохижуулах газрын тээвэр аж ахуйн хэсгийн дарга Н.Батбаяр,

**НӨГӨӨ ТАЛААС** 2788705 тоот регистрийн дугаартай, Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Стадион оргил-1 Чингисийн өргөн чөлөө-6, Кэй Би тауэр, 21 давхар хаягт оршдог “Ачит-Ихт” ХХК (цаашид “Захиалагч” гэх)-ийг төлөөлж ХАБЭАБО-ны менежер Ж.Мөнхдархан (цаашид тус тусад нь “Тал”, хамтад нь “Талууд” гэх) нар Иргэний хуулийг болон бусад хууль тогтоомжийг үндэслэн дараах нөхцөлийг харилцан тохиролцсоноор байгуулав.


### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Гэрээгээр Гүйцэтгэгч нь Захиалагчийн үйлдвэрийн ахуйн хог хаягдал болон уурын зуухнаас гарсан үнсний хаягдлыг хүлээн авч, цуглуулан, хадгалж, дарж устгах ажил (цаашид “Ажил” гэх)-ыг холбогдох хууль, дүрэм, журам, стандарт, норм, нормативын дагуу хийж гүйцэтгэх, Захиалагч нь төлбөр төлөхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Иргэний хууль болон бусад хууль, дүрэм, журам, стандартад заасны дагуу зохицуулна.
- 1.3. Талууд Гэрээнд заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгэснээр гэрээний харилцаа дуусгавар болно.
- 1.4. Энэхүү гэрээний хүчинтэй хугацаа нь 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл 1 жил байна. /Үйлдвэрийн сул зогсолтын үеийг тооцохгүй/.
- 1.5. Гэрээг байгуулснаас хойш ажлын үр дүнг хүлээлгэн өгөх хүртэл Гэрээний үнийн дүн болон хугацаанд өөрчлөлт оруулахгүй болохыг талууд харилцан тохиролцов.
- 1.6. Гүйцэтгэгч нь ажлыг хийж гүйцэтгэхдээ үйлдвэрлэлийн болон ажил гүйцэтгэж байгаа бусад этгээдийн хэвийн үйл ажиллагаанд аль болох саад учруулахгүйгээр зохион байгуулна.
- 1.7. Ажлын байр, талбайд Захиалагчийн дотоод болон аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг мөрдөж ажиллах, орон нутгийн байгууллага, оршин суугчдад хүндэтгэлтэй хандах үүрэгтэй.
- 1.8. Гэрээгээр хүлээсэн үүргээ талууд бүрэн биелүүлж, бие биенээ харилцан хүндэтгэх зарчмыг баримтлан ажиллана.

### ХОЁР. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 2.1. Гэрээний төлбөр нь 1 м<sup>3</sup> хогийг дарж устгах 11,500 (Арван нэгэн мянга таван зуун) төгрөг байна. Энэхүү үнийн дүнд ачиж тээвэрлэх болон халдваргүйжүүлэх, устгахтай болон холбогдох бүх зардал, татвар, суутгал, НӨАТ багтсан болно.
- 2.2. Захиалагч нь хог хаягдлыг дарж устгах талбай дээр буулгасан тухай сарын мэдээлэл бүхий баримт, Гүйцэтгэгчээс ирүүлсэн нэхэмжлэхийг үндэслэн 30 хоногт багтаан төлнө.
- 2.3. Гүйцэтгэгчийн төлбөр хүлээн авах дансны мэдээлэл:


Банкны нэр: Төрийн сан  
Дансны дугаар: 100210100947

|            |   |                  |            |
|------------|---|------------------|------------|
| Огноо      | Талууд гарын үсэг зурах   |                  | Хуудас 1/4 |
| 2022.02.17 | Захиалагч  | Гүйцэтгэгч _____ |            |

БАТЛАВ. UULH TRADE Co., Ltd  
“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

  
...../Н.БИЛГҮҮН/  
1116225557 ☎ 2066521

БАТЛАВ. УЛААНБААТАР ХОТ  
“АЧИТ-ИХТ” ХХК-ИЙН  
ОРЛОГЧ ЗАХИРАЛ

  
...../Д.НОМИН/  
ТТӨС797 Ж. 2788705

### АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022 оны 07 сарын 29-ний өдөр

№ Ш-22/ 22/276-А /105)

Улаанбаатар хот

Ү-

Нэг талаас **Цэцүүх трейд ХХК** /цаашид “Хүлээн авагч” гэх/ төлөөлж Үйлдвэрийн дарга албан тушаалтай Б.Дарамбазар, Нөгөө талаас “**Ачит-Ихт**” ХХК-г /цаашид “Үүсгэгч” гэх/ төлөөлж ХАБЭАБО-ны менежер албан тушаалтай Ж.Мөнхдархан бид харилцан тохиролцож Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль Засгийн газрын **2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал** болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

### Нэг. Гэрээний агуулга

- 1.1. Энэхүү гэрээгээр Аюултай хог хаягдал үүсгэгчээс аюултай хог хаягдлын дагалдах бичгийн дагуу түүнээс гарч байгаа аюултай хог хаягдлыг хүлээн авагч нь хүлээн авч хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах, үүсгэгч нь хүлээн авагчид тохиролцсон үнийг төлөх болон талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагын талаар зохицуулна.
- 1.2. Эл гэрээгээр шууд зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол улсын Хог хаягдлын тухай хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.3. Аюултай хог хаягдлын тоо хэмжээ, төрөл болон үнийн талаар гэрээний Хавсралт 1-т тусгах ба талууд гэрээний хугацаанд аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ дагалдах бичгийг гэрээнд хавсаргах ба энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

### Хоёр. Аюултай хог хаягдалд тавигдах шаардлага

- 2.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж “Аюултай хог хаягдал” гэсэн тэмдэглэгээтэй байна.
- 2.2. Аюултай хог хаягдал савласан сав бүр нь ямар химийн бодис хадгалж байсан тухай нэр шошготой байна.
- 2.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ үүссэн болон хуримтлагдсан хог хаягдлын хэмжээний талаарх бүртгэлийг хүлээн авагчид шилжүүлнэ.
- 2.4. Аюултай хог хаягдлыг шилжүүлэхдээ **БОАЖЯ Сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаалын 1-р хавсралтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг** бүрдүүлж өгнө.
- 2.5. Аюултай хог хаягдлын савыг суллаж онц хортой, тэсрэмтгий, шатамхай бодис /тухайлбал цианид натри гэх мэт/ -г тухайн бодисын шинж чанарт тохирсон үүсмалаар

  
\_\_\_\_\_

Хуудсыг баталгаажуулсан:

  
\_\_\_\_\_

Хуудас 2/11



**БАТЛАВ:**

“АЧИТ-ИХТ” ХХК-ИЙН ҮЙЛДВЭРИЙН  
ЗАХИРАЛ...../И.БАТБОЛД/



ОБЕГ-ын даргын 2019 оны 12 дугаар сарын 12-ны  
өдрийн А/388 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

**“АЧИТ-ИХТ” ХХК-ИЙН ҮЙЛДВЭРИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

/Онцгой байдлын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө/

**Боловсруулсан:** 2022 оны 02-р сарын 22-ны өдөр

**Тодотгосон:** 202.. оны .. -р сарын .. - ний өдөр

202.. оны .. -р сарын .. - ний өдөр

202.. оны .. -р сарын .. - ний өдөр

**ХЯНАСАН:**

ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨЛТ БЭЛЭН БАЙДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН, ГАМШГААС  
ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ, АХМАЛ.....Ш.ОНОНТАЛ



**БОЛОВСРУУЛСАН:**

ХАБ-Н АХЛАХ АЖИЛТАН.....Б.НЭМЭХБАЯР

**ЭРДЭНЭТ ХОТ**

**2022 ОН**



**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 7/58.

Улаанбаатар хот

**Техник-эдийн засгийн үндэслэл  
хүлээн авах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн БҮ-2019-01-01 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт орших Ачит Ихт ХХК-ийн катодын зэсийн үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэл /тодотгол/-ийг хүлээн авсанд тооцсугай.
2. Хүлээн авсан техник-эдийн засгийн үндэслэлийн үйлдвэрлэлийн нөөцийг бүртгэж, нөөцийн хөдөлгөөн хийхийг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т зөвшөөрсүгэй.
3. Техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу уулын ажил явуулах зөвшөөрөл олгох, хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т даалгасугай.
4. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан үйлдвэрийн хүчин чадал, техник, тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж байхыг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т даалгасугай.
5. Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт орших катодын зэсийн үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэл /тодотгол/-ийг диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт энэхүү тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг Ачит Ихт ХХК-д даалгасугай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН

**53700521**





## АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 28 өдөр

Дугаар Т-37

Улаанбаатар хот

### Техник-эдийн засгийн үндэслэл хүлээн авах тухай

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, "Ашигт малтмалын тухай хууль"-ийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2014 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны 14-15-08 тоот дүгнэлтийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт орших "Ачит ихт" ХХК-ийн "Эрдэнэтийн овооны блансын бус хүдэр"-ийг овоолгон уусгах технологиор боловсруулах үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэлийг хүлээн авсанд тооцсугай.

Хоёр. Техник-эдийн засгийн үндэслэл, уулын ажлын төлөвлөгөөний дагуу уулын ажил явуулах зөвшөөрөл олгох, байгаль орчны төлөвлөгөөний хэрэгжилт, зардалд хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн хэлтэс (С.Баттулга)-т даалгасугай.

Гурав. Техник, эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник, тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж байхыг Уул уурхайн хэлтэс (С.Баттулга)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ҮҮРИЙНТУЯА

10 1530



## ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

- Үндсэн нөхцөл
- Ерөнхий нөхцөл
- Тусгай нөхцөл

Зүйл нэг. Ажил олгогчийн харнуцлагын даатгал  
Зүйл хоёр. Гэнэтийн ослын даатгал  
Зүйл гурав. Эмнэлэг эмчилгээний зардлын даатгал

- Даатгалын гэрээний хавсралт

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Даатгагчийг төлөөлж:

БОДЬ ДААТГАЛ ХК-ийн  
Байгууллагын даатгалын газрын захирал

Б.Одгэрэл

Ахлах менежер

О.Одгариг



Даатгуулагчийг төлөөлж:

АЧИТ ИХТ ХХК-ийн  
Захиргаа хүний нөөцийн захирал

Н.Энхжаргал

Хуульч

Г.Золзаяа

Даатгалын гэрээг зуучлан байгуулсан:

АЧИТ УНДАРГА ХХК  
Ерөнхий захирал

Ш.Батчимэг



## ҮНДСЭН НӨХЦӨЛ

1. ДААТГАЛЫН ХЭЛБЭР: Үүнд: 1. Ажил олгогчийн хариуцлага  
2. Гэнэтийн осол  
3. Эмчилгээний зардлын даатгал
2. ДААТГУУЛАГЧИЙН ХАЯГ: Монгол Улс, Улаанбаатар хот, ХУД-дүүрэг, 15-р хороо,  
Стадион-оргил-1, Чингисийн Өргөн Чөлөө-6, Кэй Би тауэр  
21 давхар, Утас- 976-7595 1199-302
3. ДААТГУУЛАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА: Уул, уурхайн боловсруулах үйлдвэр
4. ДААТГАЛЫН ЗҮЙЛ:
- 4.1. Даатгуулагч ажилтныхаа өмнө хуулийн дагуу хүлээх хариуцлага;  
4.2 Даатгуулагчийн ажиллагсдын эрүүл мэнд, амь нас,  
4.3 Даатгуулагчийн ажиллагсдын эрүүл мэнд
5. ДААТГАЛЫН ХАМГААЛАЛТЫН ЗОРИЛГО:
- 5.1. Даатгуулагчийн хөдөлмөрийн тухай хууль, түүний 97- р зүйл болон бусад хууль тогтоомжид заасны дагуу ажилтны өмнө хариуцлага хүлээх тохиолдолд компанид учирч болзошгүй төлөвлөөгүй зардлын эх үүсвэрийг баталгаажуулах, хохирлыг даатгалаас нөхөн төлүүлэх;  
5.2. Ажилтныг бүх төрлийн гэнэтийн ослоос үүдэн хөдөлмөрийн чадвар алдах, амь нас эрсдэх тохиолдолд нөхөн төлбөр олгох;  
5.3. Ажилтанд ердийн болон халдварт өвчин, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс үүдэн учрах эмнэлэг эмчилгээний зардлыг нөхөн төлөх зорилготой.
6. ДААТГАЛЫН ХУГАЦАА: 2021/12/21- 2022/12/20 /Нэг жил/
7. ХАСАЛТ ХЭСЭГ: Гэрээнд заасанчлан
8. ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ:
- |                                |                        |
|--------------------------------|------------------------|
| 1. Ажил олгогчийн хариуцлага:  | 8,254,602,936₮         |
| 2. Гэнэтийн осол:              | 1,890,000,000₮         |
| 3. Эмнэлэг эмчилгээний зардал: | 378,000,000₮           |
| <b>Нийт үнэлгээ:</b>           | <b>10,522,602,936₮</b> |
9. ДААТГАЛЫН ЖИЛИЙН ХУРААМЖ:
- |                                |                       |
|--------------------------------|-----------------------|
| 1. Ажил олгогчийн хариуцлага:  | 23,938,348.51₮        |
| 2. Гэнэтийн осол:              | 8,505,000.00₮         |
| 3. Эмнэлэг эмчилгээний зардал: | 7,560,000.00₮         |
| <b>Нийт хураамж:</b>           | <b>40,003,348.51₮</b> |
- ХУРААМЖИЙН ХӨНГӨЛӨЛТ : Гэрээ сунгалтын хөнгөлөлтийг нийт хураамжийн дүнгээс 15% болох 6,000,502.28 төгрөг (зургаан сая таван зуун хоёр мянган төгрөг хорин найман мөнгө) -ийг хасч тооцно.
- ТӨЛӨХ ХУРААМЖ: 34,002,846.23 төгрөг



(Гучин дөрвөн сая хоёр мянга найман зуун дөчин зургаан төгрөг  
хорин гурван мөнгө)

10 ГАЗАР ЗҮЙН ХЯЗГААР:

Монгол Улс болон дэлхийн бусад оронд томиллолтоор ажиллах,  
аялах хугацаанд 24 цагийн хугацаанд хүчинтэй үйлчилнэ.

11 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ:

Монгол Улсын хууль

12 ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ ЗОХИЦУУЛАЛТ:

Даатгуулагчийн жагсаалтанд өөрчлөлт оруулахад  
холбогдох ажилтан, түүний хаяг:

Байгууллагын даатгалын газрын захирал: Б.Одгэрэл

И-мейл хаяг: [odgerel.b@bodi-insurance.com](mailto:odgerel.b@bodi-insurance.com)

Утас: 70110280, 99054810

Ахлах менежер: О.Одгариг

И-мейл хаяг: [odgarig.o@bodi-insurance.com](mailto:odgarig.o@bodi-insurance.com)

Утас: 70110280, 99051840

13 ХОХИРЛЫН НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ:

Даатгалын тохиолдлын талаар нэн даруй доорх хаягаар  
мэдэгдэнэ. Утас: 70004800

Шуурхай албаны утас: 99054800

Нэхэмжлэлийн материалыг доорх хаягийн дагуу  
хариуцсан нөхөн төлбөрийн мэргэжилтэн рүү явуулна.

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн  
хуулийн гудамж, 4 – 2 тоот Таван Өндөр Төв

Нөхөн төлбөрийн мэргэжилтэн: М.Уртнасан

И-мейл хаяг: [urtnasan.m@bodi-insurance.com](mailto:urtnasan.m@bodi-insurance.com)

Утас: 88020264

14 ТӨВ ОФФИС ХАЯГ:

Бодь цамхаг, 3-дугаар давхар. Жигжиджавын гудамж 3,

/Их эзэн Чингис хааны талбай/

Улаанбаатар хот, МОНГОЛ УЛС

Утас: + (976) 70110280 Факс: + (976) 11328311





## ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү даатгалын гэрээгээр нэг талаас даатгуулагч нь даатгалын хураамж төлж ажилтнуудын өмнө хуулийн хариуцлага хүлээх, ажилтан бүх төрлийн гэнэтгийн осолд өртөх, мэргэжлээс шалтгаалан өвчлөх, хөдөлмөрийн чадвар, амь насаа алдахад нөхөн төлбөр төлөх, эмчилгээний зардлын эрсдэлийг даатгуулан хохирлыг төлөх эх үүсвэрийг баталгаажуулах, нөгөө талаас даатгагч нь даатгалын тохиолдол бий болсон нөхцөлд даатгалын хэлбэр тус бүрд заасны дагуу нөхөн төлбөр төлөх, даатгуулагчийг ажилтны өмнө хүлээх хуулийн хариуцлагаас чөлөөлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2 Даатгалын гэрээ нь гэрээний үндсэн нөхцөл, ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл болон гэрээний хавсралтуудаас бүрдэж тэдгээрийн хамт хүчин төгөлдөр байх ба хавсралтууд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
- 1.3 Гэрээний ерөнхий нөхцөлд тусгай нөхцөлөөс өөрөөр заасан бол тусгай нөхцөлийн заалтыг дагаж мөрдөнө.
- 1.4 Хоёр тал энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль болон гэрээг хэрэгжүүлэхэд холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 1.5 Даатгагч нь Даатгуулагчийн зарласан сонгон шалгаруулалтад тавьсан нөхцөлийг хүлээн зөвшөөрч Талууд даатгалын нөхцөл, үнэлгээ хураамжийг тохиролцсон бөгөөд сонгон шалгаруулалтын материал нь энэхүү гэрээ байгуулах үндэслэл болно.

### ХОЁР. НЭР ТОМЬЕОНЫ ТАЙЛБАР

Энэхүү гэрээнд хэрэглэсэн нэр томьёонуудыг дор дурдсан утгаар ойлгоно.

- 2.1 ДААТГАГЧ гэж энэхүү гэрээний дагуу эрсдэл, даатгалын үнэлгээ, хураамжийг хүлээн авч буй Бодь Даатгал ХК-г;
- 2.2 ДААТГУУЛАГЧ гэж энэхүү гэрээнд заасан эрсдэлийг шилжүүлэн хураамж төлж буй “Ачит-Ихт” ХХК, түүний ажилтан, ажиллагсдыг;
- 2.3 АЖИЛТАН гэж Даатгуулагчтай хөдөлмөрийн гэрээ, контракт байгуулан ажиллаж байгаа хавсралтад нэр заасан ажилтнуудыг;
- 2.4 ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ гэж энэхүү гэрээнд зуучлан ажиллаж байгаа даатгалын мэргэжлийн оролцогчийн тусгай зөвшөөрөл бүхий “Ачит-Ундарга” ХХК-ийг;
- 2.5 ДААТГАЛЫН ЭРСДЭЛ Гэрээнд заасан даатгалын хэлбэр тус бүрд тодорхойлсныг;
- 2.6 ДААТГАЛЫН ТОХИОЛДОЛ Даатгалын эрсдэлийн улмаас даатгуулагч, түүний ажилтанд учирсан хохирлыг Даатгагч хариуцан арилгах үүрэг хүлээх, тохиролцсон болзол бүрдэхийг;
- 2.7 НӨХӨН ТӨЛБӨРИЙН НЭХЭМЖЛЭЛ Даатгалын тохиолдол бий болсон хэмээн үзэж даатгалын нөхөн төлбөр олгохыг хүссэн албан бичиг, өргөдлийг;
- 2.8 ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ Даатгалын зүйлийг талууд харилцан тохиролцож тогтоосон мөнгөн илэрхийллийн хэмжээг; даатгалын гэрээтэй холбогдох зардал гэж даатгалын гэрээг байгуулахад даатгалын хураамжаас тооцож даатгалын төлөөлөгч болон зуучлагчид олгох хөлсний хувь хэмжээг;
- 2.9 ДААТГАЛЫН ГЭРЭЭТЭЙ ХОЛБОГДОХ ЗАРДАЛ ГЭЖ Даатгалын гэрээг байгуулахад даатгалын хураамжаас тооцож даатгалын төлөөлөгч болон зуучлагчид олгох хөлсний хувь хэмжээг
- 2.10 ӨӨРИЙН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА Даатгалын тохиолдол бий болсон нөхцөлд даатгалын зүйлд учирсан хохирлоос даатгуулагчийн хариуцах хэсгийг;
- 2.11 ХАСАЛТ ХЭСЭГ Даатгагч даатгалын нөхөн төлбөр олгохгүй байх хууль болон энэхүү гэрээнд заасан нөхцөлүүдийг;
- 2.12 ДААТГАГЧ ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГЭЭ БҮРЭН БИЕЛҮҮЛСЭН: Даатгагчаас даатгалын





- гэрээгээр тохирсон нийт үнэлгээний дээд хязгаарыг дуустал нөхөн төлбөр төлсөн байх нөхцөлийг;
- 2.13 НЭН ДАРУЙ  
Даатгалын тохиолдлыг мэдэгдэх 72 цагийн хугацааг;
- 2.14 ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДАЛТ  
Даатгалын тохиолдлын улмаас даатгуулагчийн ажилтан 182 хоног хүртэл хугацаагаар ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй болох нөхцөлийг;
- 2.15 ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДАЛТ  
Даатгалын тохиолдлын улмаас даатгуулагчийн ажилтан бүрмөсөн эсвэл тодорхой хугацаанд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгохыг;
- 2.16 ЭМЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ  
Даатгалын тохиолдлын улмаас зайлшгүй хийлгэх шаардлагатай оношилгоо, эмчилгээ, сувилгаа, эм тариа, сэргээн засах эмчилгээний зардлыг;
- 2.17 ЯАРАЛТАЙ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТ  
Даатгалын тохиолдлын үед ажилтныг эмчийн заавраар эмнэлэгт яаралтай шилжүүлэх шаардлага үүссэний үндсэн дээр хамгийн ойр эмнэлэгт хүргэхийг;
- 2.18 ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА  
Даатгалын зүйлд хохирол учирсан нөхцөлд хуулийн дагуу тухайн тохиолдлыг шалгах, шийдвэрлэх байгууллага, алба тушаалтныг;
- 2.19 ХҮНДЭТГЭН ҮЗЭХ ШАЛТГААН  
Энэхүү гэрээний эрсдэлд зааснаас бусад давагдашгүй хүчин зүйлс, хүнд нөхцөл байдал зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамааран гэрээний эрх, үүргийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэнийг ойлгоно.
- 2.20 АЖЛЫН ЦАГ  
Ажлын цаг гэдэгт ажилдаа ирэх очих, илүү цагаар хөдөлмөрлөх, гадаад, дотоодод томилолтоор ажиллах, гадуур ажиллах, ажил олгогчоос албан ёсоор зохиосон арга хэмжээнд ирэх очих хугацааг ойлгоно.
- 2.21 ХАМТАРСАН КОМИСС  
Даатгуулагч, даатгагчаас томилж даатгалын тохиолдлыг шалгах баталгаажуулахаар томилсон ажлын хэсгийг ойлгоно.

## ГУРАВ. ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ, ХУРААМЖ

- 3.1 Энэхүү гэрээнд Талууд даатгалын үнэлгээ, хураамжийн хэмжээг дор дурдсан хэмжээгээр тогтож хэлэлцэн тохиров. Үүнд:
- 3.1.1 Ажил олгогчийн хариуцлагын даатгал: Талууд даатгалын үнэлгээг Хүснэгт 1-д заасан ажлын байрны тоо, цалингийн шатлалаар нэг ажлын байранд 36 сарын цалингийн дундажтай тэнцүү байхаар хэлэлцэн тогтоож дор дурдсан хувиар хураамжийг тооцон төлөхөөр тогтов.

### Хүснэгт 1. Ажил олгогчийн хариуцлагын даатгалын үнэлгээ, хураамжийн хувь хэмжээ

| № | Шатлал      | Ажлын байр /цалингийн шатлалаар/                             | Үнэлгээ                 | Хураамжийн хувь | Хураамж                |
|---|-------------|--|-------------------------|-----------------|------------------------|
| 1 | Шатлал 1.   | Цалингийн дундаж 1,347,015 сая төгрөг хүртэл ажлын байр - 87 | 4,218,850,980.00        | 0.29%           | 12,234,667.84          |
| 2 | Шатлал 2.   | Цалингийн дундаж 1,844,643.00 төгрөг хүртэл ажлын байр - 18  | 1,195,328,664.00        | 0.29%           | 3,466,453.13           |
| 3 | Шатлал 3.   | Цалингийн дундаж 2,454,545.00 төгрөгөөс дээш ажлын байр - 8  | 706,908,960.00          | 0.29%           | 2,050,035.98           |
| 4 | Шатлал 4.   | 3,466,667.00 төгрөгөөс дээш ажлын байр - 6                   | 748,800,072.00          | 0.29%           | 2,171,520.21           |
| 5 | Шатлал 5.   | 7,692,857.00 төгрөгөөс дээш ажлын байр - 5                   | 1,384,714,260.00        | 0.29%           | 4,015,671.35           |
|   | <b>Нийт</b> |  | <b>8,254,602,936.00</b> | <b>0.29%</b>    | <b>23,938,348.51₮</b>  |
|   |             |  | <b>Хөнгөлөлт</b>        | <b>15.00 %</b>  | <b>3,590,752.28₮</b>   |
|   |             |  | <b>Төлөх хураамж:</b>   |                 | <b>20,347,596.24 ₮</b> |



3.1.2 Гэнэтийн ослын даатгалд Хавсралт 1-д нэр дурдсан ажилтнуудыг даатгаж Хүснэгт 2-т заасан даатгалын үнэлгээ хураамжтай байхаар хэлэлцэж тохиров.

**Хүснэгт 2 Гэнэтийн ослын даатгалын үнэлгээ хураамжийн хувь хэмжээ**

| № | Ажилчдын тоо | Даатгалын үнэлгээ I ажилтны хувьд | Нийт Үнэлгээ          | Хураамжийн хувь | Нийт Хураамж         |
|---|--------------|-----------------------------------|-----------------------|-----------------|----------------------|
| 1 | 189          | 10,000,000.00                     | 1,890,000,000.00      | 0.45%           | 8,505,000.00         |
|   |              |                                   | <b>Хөнгөлөлт</b>      | 15.00 %         | 1,275,750.00         |
|   |              |                                   | <b>Төлөх хураамж:</b> |                 | <b>7,229,250.00₮</b> |

3.1.3. Эмчилгээний зардлын даатгалыг Хавсралт 1-д нэр дурдсан ажилтанд дараах даатгалын үнэлгээ, хураамжтай даатгахаар хэлэлцэн тохиров.

**Хүснэгт 3 Эмчилгээний зардлын даатгал**

| № | Ажилчдын тоо | Даатгалын үнэлгээ I ажилтны хувьд | Нийт Үнэлгээ          | Хураамжийн хувь | Нийт Хураамж       |
|---|--------------|-----------------------------------|-----------------------|-----------------|--------------------|
| 1 | 189          | 2,000,000.00                      | 378,000,000.00        | 2.00%           | 7,560,000.00       |
|   |              |                                   | <b>Хөнгөлөлт</b>      | 15.00 %         | 1,134,000.00       |
|   |              |                                   | <b>Төлөх хураамж:</b> |                 | <b>6,426,000 ₮</b> |

**Нийт хураамж: 40,003,348.51 ₮**

**Хөнгөлөлтийн дүн 15.00 % 6,000,502.28 ₮**

**Хөнгөлөлттэй төлөх дүн 34,002,846.24₮**

3.2 Гэрээний хугацаанд Даатгагчаас төлөх нөхөн төлбөрийн нийт хэмжээ нь даатгалын үнэлгээний нийт дүнгээс хэтрэхгүй.

3.3 Даатгуулагч даатгалын хураамжийг дор дурдсан хуваарийн дагуу Бодь Даатгал ХК-ийн Богд Банкин дахь төгрөгийн 8001001367 тоот дансанд шилжүүлнэ.

| Хураамж төлөлт | Төлөх Хугацаа | Хураамжийн Хувь | Хураамжийн дүн        |
|----------------|---------------|-----------------|-----------------------|
| 1 дэх төлөлт   | 2021-12-29    | 40%             | 13,601,138.49₮        |
| 2 дах төлөлт   | 2022-03-29    | 30%             | 10,200,853.87₮        |
| 3 дах төлөлт   | 2022-06-29    | 30%             | 10,200,853.87₮        |
| <b>Нийт</b>    |               |                 | <b>34,002,846.24₮</b> |

3.4 Гэрээнд талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

3.5 Даатгагч нь гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш гэрээний хуваарийн дагуу эхний хураамж төлөх хүртэл хугацаанд учирсан хохирлыг гэрээний дагуу нөхөн төлнө.

3.6 Даатгалын гэрээний хураамжийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй үед Даатгагч 30 хоногийн нэмэлт хугацаа тогтоож өгөх бөгөөд үүнээс хэтэрсэн хугацаанд хураамж төлөгдөөгүй байх үед хохирол учирсан тохиолдолд Даатгагч нөхөн төлбөр төлөх үүргээс чөлөөлөгдөнө.

3.7 Гэрээнд заасан хуваарийн дагуу хураамжийг хувааж төлөх нь даатгагч гэрээний хураамжийн төлөлтөд тохируулж нөхөн төлбөрийг хувь тэнцүүлэн төлөх нөхцөл болохгүй.

3.8 Ажилтан тус бүрийн овог нэр, регистрийн дугаар, мэргэжил, эрхэлдэг ажил, албан тушаал, даатгалын үнэлгээ, хураамж, нөхөн төлбөр авах эрхтэй этгээдийг зааж холбогдох мэдээллийг гэрээнд хавсаргана.

**ДӨРӨВ. ДААТГАЛЫН ГЭРЭЭ ҮЙЛЧЛЭХ ХУГАЦАА, ГЭРЭЭГ ЦУЦЛАХ, ХУРААМЖИЙН БУЦААЛТ**



- 4.1 Талууд өөрөөр тохиролцоогүй бол талууд гэрээнд гарын үсэг зурснаар даатгалын хамгаалалт хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд даатгалын хураамжийг даатгагчаас олгосон нэмэлт хугацаанд төлөөгүй үед үүссэн даатгалын тохиолдолд даатгагч нөхөн төлбөр төлөх үүргээс чөлөөлөгдөнө.
- 4.2 Энэхүү гэрээг Талууд гарын үсэг зурж тамга тэмдгээр баталгаажуулснаас хойш хүчин төгөлдөр болох бөгөөд 4.6-д заасны дагуу гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгоогүй бол гэрээнд заасан хугацаа хүртэл үйлчилнэ.
- 4.3 Талуудын аль нэг нь гэрээг дангаар цуцлах эрхгүй бөгөөд гэрээнээс татгалзах, цуцлах саналтай тохиолдолд 3 сарын өмнө урьдчилан нөгөө талдаа бичгээр үндэслэлийг зааж мэдэгдэнэ.
- 4.4 Даатгалын гэрээ хугацаанаас өмнө дуусгавар болсон нөхцөлд даатгалын хураамжаас гэрээ үйлчилж байсан хугацаанд ногдох хураамж болон гэрээтэй холбогдох зардал, үйлчилгээний төлбөрийг хасаж тооцон даатгуулагчид даатгалын хураамжийн буцаалт хийгдэнэ. Даатгалын гэрээтэй холбогдох зардлыг даатгалын хураамжийн 20 хувиар, үйлчилгээний төлбөрийн хэмжээг 10 хувиар тооцон суутгаж үлдэх хэсгийг даатгуулагчийн дансанд шилжүүлнэ.
- 4.5 Даатгалын хугацаанд даатгалын тохиолдол бий болж нөхөн төлбөр төлсөн, даатгалын гэрээ байгуулснаас хойш 11 сарын хугацаа өнгөрсөн бол даатгалын гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгохтой холбоотой даатгалын хураамжийн буцаалт хийгдэхгүй.
- 4.6 Даатгалын гэрээ дараах тохиолдолд дуусгавар болно.
  - 4.6.1 Хууль, гэрээгээр тогтоосон хугацаа дуусгавар болсон;
  - 4.6.2 Даатгагч, даатгуулагчийн аль нэг дамнуурсан, татан буугдсан;
  - 4.6.3 Шүүх гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцсон;
  - 4.6.4 Гэрээнд заасан хугацаанаас өмнө гэрээг дуусгавар болгохоор талууд тохиролцсон;
  - 4.6.5 Даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн;
- 4.7 Гэрээний хугацаа дууссан тохиолдолд талууд энэхүү нөхцөлөөр цаашид үргэлжлүүлэн сунгах талаар хэлэлцэн тохиролцож гэрээг шинэчлэн байгуулна.

## **ТАВ. БУСАД**

### **5.1 ДАВХАРДСАН ДААТГАЛ**

Даатгуулагч энэхүү гэрээгээр даатгагдсан даатгалын зүйлийг хэд хэдэн даатгагчид нэгэн зэрэг даатгуулсан бол даатгалын нөхөн төлбөрийн нэхэмжлэлийн үед энэ тухай даатгагчид мэдэгдэх үүрэгтэй.

### **5.2 АНХДАГЧ ШАЛТГААНЫ ЗАРЧИМ**

Даатгалын зүйлд хохирол учрах анхдагч шалтгаан болсон нөхцөлийг даатгалын зүйлд хохирол учруулсан эрсдэл гэж ойлгоно.

### **5.3 ГЭРЭЭНД БАРИМТЛАХ ЗАРЧИМ:**

Энэхүү гэрээнд даатгагч нь гэрээ байгуулагдсанаар даатгалын үйлчилгээг гэрээний дагуу бүрэн хүндрэлгүй үзүүлэх, даатгуулагч нь хураамж төлж, гэрээнд заасан эрсдэлээс учирсан хохирлоо хэлэлцэн тохирсон хэмжээнд шуурхай нөхөн төлүүлж үйлчилгээгээ бүрэн авах зарчмыг баримтална.

### **5.4 ДААТГАЛЫН ТОХИОЛДЛЫН ШИНЖ**

Даатгалын тохиолдол нь гэнэтийн, урьдчилан таамаглах боломжгүй, ирээдүйд бий болох эсэх нь тодорхой бус, даатгуулагчийн хүсэл зоригоос үл хамаарсан шинжийг хангасан байна. Ажил олгогчийн хариуцлагын гэрээнд энэ хэсэг үл хамаарна.

### **5.5 МАРГААН**

Энэхүү гэрээ, түүний гүйцэтгэлтэй холбоотой асуудлаар талуудын хооронд маргаантай асуудал үүсвэл юуны өмнө эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Хэрэв ийнхүү шийдвэрлэж чадахгүйд хүрвэл Санхүүгийн зохицуулах хороо, Монгол улсын шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

### **5.6 ГЭРЭЭНИЙ НУУЦЛАЛ**

Талууд гэрээний хугацаанд ажил үүргийн шаардлагаар олж мэдсэн, эзэмшиж, ашиглаж байсан баримт бичиг, мэдээ материал болон талуудын бизнесийн ашиг сонирхолд шууд болон шууд бус хамааралтай компанийн мэдээлэл, байгууллага, хувь хүний нууц, ноу-хау зэргийг хуульд зааснаас бусад тохиолдолд задруулахгүйгээр чанд хадгална.

### **5.7 ДАВХАР ДААТГАЛ- даатгагч нь энэхүү гэрээгээр даатгуулагчаас шилжүүлэн авсан эрсдэлийг давхар даатгалд хамруулах бөгөөд давхар даатгасныг гэрчлэх баримт, төлбөрийн баримтыг гэрээ байгуулагдсанаас хойш 10 хоногт багтаан Даатгуулагчид ирүүлнэ.**

### **5.8 ГЭРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ДҮГНЭХ, ДААТГАЛЫН ТОХИОЛДЛЫГ БАТАЛГААЖУУЛАХ**






5.8.1 Талууд даатгалын гэрээг хэрэгжүүлж ажиллах ажилтныг томилон ажиллуулах бөгөөд улирал тутамд гэрээг дүгнэж баталгаажуулна.

|   | Даатгуулагчийг төлөөлж     | Албан тушаал                          | Холбогдох утас, Е-мэйл  |
|---|----------------------------|---------------------------------------|---|
| 1 | Г.Золзаяа                  | Хуульч                                | <a href="mailto:zolzaya.g@achit-ikht.mn">zolzaya.g@achit-ikht.mn</a><br>85000807                |
|   | Ш.Батчимэг                 | Даатгалын зөвлөх                      | 99113263 <a href="mailto:batchimeg@magicspring.mn">batchimeg@magicspring.mn</a>                 |
|   | Ж.Мөнхдархан               | ХАБЭА-н менежер                       | <a href="mailto:munkhdarkhan@achit-ikht.mn">munkhdarkhan@achit-ikht.mn</a><br>99106762          |
|   | Б.Дэлгэрмаа                | Хүний нөөц                            | <a href="mailto:delgermaa@achit-ikht.mn">delgermaa@achit-ikht.mn</a><br>99943111                |
|   | Ц.Даваадорж                | Хүний нөөцийн ажилтан                 | <a href="mailto:davaadorj.ts@achit-ikht.mn">davaadorj.ts@achit-ikht.mn</a><br>94351918          |
|   | <b>Даатгагчийг төлөөлж</b> | <b>Албан тушаал</b>                   | <b>Холбогдох утас, Е-мэйл</b>   |
| 2 | Б.Одгэрэл                  | Байгууллагын даатгалын газрын захирал | 99054810 <a href="mailto:odgerel.b@bodi-insurance.com">odgerel.b@bodi-insurance.com</a>         |
|   | М.Уртнасан                 | Нөхөн төлбөрийн ахлах менежер         | 88020264 <a href="mailto:urtnasan.m@bodi-insurance.com">urtnasan.m@bodi-insurance.com</a>       |
|   | Д.Бямбаахүү                | Орхон салбарын захирал                | 99031421 70350712<br><a href="mailto:erdenet@bodi-insurance.com">erdenet@bodi-insurance.com</a> |

- 5.8.2 Талууд даатгалын гэрээнд заасан эрсдэлээс хохирол учирсан нөхцөлд даатгалын тохиолдлыг шалгах баталгаажуулахад хүндрэлгүй, хэрэгжих боломжтой нөхцөлөөр баталгаажуулахыг эрмэлзэж хамтран ажиллах бөгөөд үйлдвэр дээр гарсан осол, зам тээврийн ослыг баталгаажуулахад шаардлагатай тохиолдолд хамтарсан комиссыг байгуулж ажиллана. Комиссын бүрэлдэхүүнд дээр дурдсан гэрээ хариуцан ажиллах албан тушаалтнуудаас гадна нэмж өөрсдийн төлөөллийг оруулж болно.
- 5.8.3 Даатгагчийн зүгээс нөхөн төлбөр олгоход шаардах баримт бичиг нь олж авахад бэрхшээлтэй байх ёсгүй бөгөөд даатгуулагчийн бизнесийн үйл ажиллагаа, нэр хүндэд хохирол учруулахааргүй байна. Талуудын хамтарсан комисс даатгалын тохиолдлыг тогтооход оролцож биечлэн шалгасан, баталгаажуулсан тохиолдолд эрх бүхий байгууллагын тодорхойлолт шаардахгүй.
- 5.8.4 Даатгагчаас хохирол учирсан талаар нарийвчлан шалгах шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн этгээдээр шинжилгээ хийлгэх эрхтэй.
- 5.8.5 Даатгагч нь үйлдвэрийн осол, ажлын байранд ажилтан амь нас эрсдэх тохиолдолд шүүх эмнэлгийн шинжилгээ, задлан шинжилгээ хийх нөхцөлд даатгуулагчийн төлөөллийг заавал байлцуулж хамтарч ажиллана.
- 5.8.6 Даатгуулагч, түүний ажилтан даатгалын гэрээний аль ч хэлбэрээр нөхөн төлбөрийг давхардуулан нэхэмжлэх эрхтэй. Ажилтан гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгалаар нөхөн төлбөр авах нь даатгагчаас ажил олгогчийн хариуцлагын даатгалын гэрээний дагуу нөхөн төлбөр төлөхөөс татгалзах нөхцөл болохгүй.
- 5.8.7 Даатгагч даатгалын тохиолдлыг бууруулах зорилгоор даатгуулагчийн ажлын байранд жилд 2-оос доошгүй удаа сургалт семинарыг зохион байгуулах ба галын болон онцгой байдлын мэргэжлийн багийг өөрсдийн зардлаар даатгуулагчийн боломжийг харгалзан хамтран зохион байгуулна.
- 5.8.8 Даатгуулагчийн ажлын байран дээрх эрсдэлийг бууруулах ханын самбар, аюулгүй ажиллагааны заавар зөвлөмж гэх мэт сурталчилгааны зүйлсийг даатгуулагчийн хүсэл сонирхлыг харгалзан өөрийн зардлаар байршуулна.
- 5.8.9 Гэрээт хугацаанд нурууны өвчлөлтэй холбоотой эрсдэлийг бууруулах зардалд 1,5 сая төгрөгийн зардлаар уламжлалт, эсвэл аарцаг нурууны барна заслын эмнэлэгтэй хамтран үйлдвэрийн ажиллагсдыг оношлогоонд хамруулах үйлчилгээг үзүүлнэ.
- 5.8.10 Нөхөн төлбөртэй хамаатай гомдол саналыг гэрээ хариуцсан мэргэжилтэн болон харилцагчийн үйлчилгээний баг хамтран тогтмол авч байнгын эргэх холбоотойгоор анхаарал тавьж шуурхай шийдвэрлэх асуудалд хяналт тавьж ажиллана.



5.8.11 Энэхүү гэрээг даатгуулагчийн сонгосон даатгалын мэргэжлийн оролцогчоор зуучлуулан байгуулна.

## ЗУРГАА: ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

### 6.1. ДААТГАГЧИЙН ЭРХ

- 6.1.1. Гарсан-хохирлыг-газар-дээр нь-шалгах,-эрх бүхий-комиссоос хохирол-гарсан-шалтгаан,-хохирлын хэмжээг тогтооход оролцох;
- 6.1.2. Монгол улсын даатгалын тухай хуулийн 8.5-д заасан үндэслэл үүссэн тохиолдолд даатгалын нөхөн төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн олгохоос татгалзах;
- 6.1.3. Даатгуулагчийн эрх үүрэг нь шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд даатгагч гэрээнд өөрчлөлт оруулах саналыг шинэ эзэмшигчид тавих;
- 6.1.4. Даатгуулагч хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд үүргээ биелүүлэхийг шаардах, гэрээнд өөрчлөлт оруулахыг шаардах;
- 6.1.5. Ажилтны эрүүл мэнд, ажлын нөхцөлтэй газар дээр нь шалгаж танилцах.
- 6.1.6. Даатгалын гэрээ байгуулах үед ажил олгогчийн үйлдвэрлэлийн нөхцөл, ажиллагсдын эрүүл мэндийн байдалтай танилцах, шаардлагатай тохиолдолд ажилтныг эмчийн үзлэгт оруулахыг шаардах.

### 6.2. ДААТГАГЧИЙН ҮҮРЭГ

- 6.2.1. Даатгалын тохиолдол бий болсон үед нөхөн төлбөрийг хууль болон гэрээгээр тохиролцсон хугацаа, хэмжээнд олгох;
- 6.2.2. Даатгалын хууль тогтоомж, гэрээний нөхцөлийг даатгуулагчид танилцуулах;
- 6.2.3. Монгол улсын хуулиар зөвшөөрснөөс бусад нөхцөлд даатгуулагчийн талаарх мэдээ, материалын нууцыг задруулахгүй байх;
- 6.2.4. Даатгалын эрсдэлийн улмаас учирч болох хохирлын хэмжээг багасгахын төлөө даатгуулагчийн авсан арга хэмжээний өртгийг гэрээнд тохирсон хэмжээнд даатгалын нөхөн төлбөр дээр нэмж оруулан даатгуулагчид төлөх;
- 6.2.5. Ажилтан нас барсан тохиолдолд түүний эрх, үүргийг хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагчид нь шилжүүлэх;
- 6.2.6. Даатгалын нөхөн төлбөрийг ажилтны дансанд шууд шилжүүлэх бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээ, төлсөн хугацаа нэхэмжлэлийн дүнгийн мэдээллийг төлбөр төлсөн даруйд даатгуулагчид цахим шуудангаар мэдэгдэж байх;
- 6.2.7. Хохирол учирсан тохиолдолд даатгалын тохиолдлыг баталгаажуулахад томилсон комиссын ажилтныг цаг алдалгүй илгээх, хохирлын материалыг хүндрэлгүй бүрдүүлэхэд даатгуулагчид зааварчилгаа өгч хамтран ажиллах;
- 6.2.8. Шаардлагагүй нэмэлт материал шаардаж даатгалын нөхөн төлбөр авахад хүндрэл учруулахгүй байх, 24 цагийн турш дуудлага мэдээлэх, зааварчилгаа авах боломжийг бүрдүүлж ажиллах;
- 6.2.9. Даатгагчийн нөөц сан, санхүүгийн аюулгүй байдалд нөлөөлж болохуйц томоохон дүнтэй даатгалын хохирол учирсан, их хэмжээний хохирол нэхэмжлэх нөхцөл үүссэн нөхцөлд Даатгуулагчид мэдээлэх;
- 6.2.10. Хавсралт 1-д заасан ажилтан гэрээнээс хасагдах, нэмэгдэх тохиолдолд хураамжийн тохиргоо хийж хураамжийн буцаалтыг гэрээнд заасны дагуу хийх, гэрээнд нэмэлт өөрчлөлтөөр ажилтныг нэмж хамруулах;
- 6.2.11. Гэрээний эрсдэлийг давхар даатгалд хамруулах, энэ тухай баримт нотолгоог гэрээнд заасан хугацаанд Даатгуулагчид ирүүлэх;

### 6.3. ДААТГУУЛАГЧИЙН ЭРХ

- 6.3.1. Даатгалын тохиолдол болсон үед хууль болон гэрээний нөхцөлийн дагуу нөхөн төлбөр олгохыг даатгагчаас шаардах;
- 6.3.2. Даатгалын нөхцөл, үнэлгээ, хураамжийн хувь хэмжээ, нөхөн төлбөр олгох журмын талаар даатгагчаас нэмэлт тодруулга шаардах;





- 6.3.3. Даатгагч хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд үүргээ биелүүлэхийг шаардах, эсхүл түүнд өөрчлөлт оруулахыг шаардах;
- 6.3.4. Даатгуулагч даатгалын тохиолдол болсны улмаас учирсан хохирлын шалтгаан нөхцөл, хэмжээг үнэн зөв тогтоохын тулд хууль, хяналтын байгууллага, цагдаа, галын байгууллага, эмнэлэг зэрэг мэргэжлийн байгууллагаар акт тогтоолгох;
- 6.3.5. Хамтарсан комисс байгуулж даатгалын тохиолдлыг баталгаажуулахад оролцох, шүүх задлан шинжилгээний бүрэлдэхүүнд төлөөллөө оролцуулах;
- 6.3.6. Хохирлын хэмжээг үнэн зөв тогтоох зорилгоор даатгагчтай бүх талаар идэвхтэй хамтран ажиллах;
- 6.3.7. Даатгуулагчийн эрх үүрэг шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд шинэ эзэмшигч гэрээнд өөрчлөлт оруулах саналыг даатгагчид тавих;
- 6.3.8. Даатгуулагч нь гэрээний хавсралт 1-д заасан даатгуулсан ажилтнуудын жагсаалтад өөрчлөлт /ажлаас гарсан, шинэ орон тоо нэмэгдсэн, ажлаас гарсан хүний оронд орсон, өвчтэй, чөлөөтэй хүний оронд хугацаатай хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллаж байгаа гэх мэт/орсон тохиолдолд даатгагчийн холбогдох ажилтанд энэ тухай И-мэйлээр мэдэгдэж холбогдох өөрчлөлтийг оруулна.
- 6.3.9. Даатгалын гэрээг цуцлах, даатгалын гэрээнд дурдсан нөхөн төлбөр аваагүй ажилтан гэрээнээс хасагдах тохиолдолд хураамжийн үлдэх хэсгийг гэрээнд заасны дагуу шаардах эрхтэй.

#### 6.4. ДААТГУУЛАГЧИЙН ҮҮРЭГ

- 6.4.1. Даатгалын хураамжийг энэхүү гэрээнд тохиролцсон хэмжээ заасан хугацаа, хуваарийн дагуу Даатгагчид төлөх;
- 6.4.2. Даатгалын гэрээ байгуулахад даатгагчаас шаардсан баримт материалыг даатгагчид үнэн зөв өгөх.
- 6.4.3. Даатгалын зүйлийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгалын тохиолдол болсон үед хохирлыг багасгах зорилгоор бололцоотой арга хэмжээ авах;
- 6.4.4. Даатгалын тохиолдол бий болсон тухай даатгагчид нэн даруй буюу 24 цагийн дотор, холбоо барих боломжгүй орчин нөхцөлд 72 цагийн дотор (шуурхай албаны утас: 99054800, мессеж: 99054810, факс: 328311, албан бичиг зэрэг боломжтой арга хэлбэрээр) нэн даруй мэдэгдэх, шалтгааныг тогтоолгоход оролцуулах, даатгагч оролцох боломжгүй нөхцөлд түүний өгсөн заавар зөвлөмжийн дагуу шаардлагатай бүхий л арга хэмжээг авч баримтжуулах;
- 6.4.5. Ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны нөхцөл орчныг бүрдүүлэх;
- 6.4.6. Ажиллагсдын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны норм, стандарт, дүрэм, журмыг мөрдөх.
- 6.4.7. Нөхөн төлбөрийн баримтуудыг даатгалын тохиолдол бий болсон өдрөөс хойш хуанлийн 12 сард багтаан нэхэмжлэх, даатгагчид бүрэн гүйцэд хүлээлгэн өгөх;
- 6.4.8. Шинээр ажилтан нэмэгдэх хасагдах тохиолдолд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, нэмэлт хураамжийг төлөх;

#### ДОЛОО: НӨХӨН ТӨЛБӨР

- 7.1. Даатгалын нөхөн төлбөр олгох үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль, Иргэний хууль, Даатгалын тухай хууль болон түүнд нийцүүлэн СЗХ-ноос гаргасан журам, заавар болон энэхүү даатгалын гэрээгээр зохицуулагдана.

#### 7.2. НӨХӨН ТӨЛБӨРИЙН БАРИМТ

Даатгуулагч нь даатгалын нөхөн төлбөр нэхэмжлэхэд дараах нөхөн төлбөрийн баримтуудаас даатгагчийн зааварчилсаны дагуу аль шаардлагатайг даатгагчийн нөхөн төлбөр хариуцсан ажилтанд хүлээлгэж өгнө. Үүнд:

- 7.2.1. Нөхөн төлбөрийн нэхэмжлэл;
- 7.2.2. Шаардлагатай үед даатгалын тохиолдлыг хамтарсан комиссоос баталгаажуулсан акт, эрх бүхий байгууллагын шийдвэр;
- 7.2.3. Хөдөлмөрийн чадвар алдалтын хугацаа, хувь хэмжээг тогтоосон эмнэлэг-хөдөлмөр магадлах комиссын акт, эмнэлгийн хуудас/лист, эмчийн онош бүхий эмнэлгийн магадлагаа, эм тарна худалдан авсан баримт, эмнэлгийн үйлчилгээ төлбөр төлсөн баримт;
- 7.2.4. Ажилтан нас барсан тохиолдолд нас барсны гэрчилгээ, нөхөн төлбөр авах эрхтэй этгээдийн иргэний үнэмлэхийн хуулбар, өв залгамжлах эрхийг баталгаажуулсан баримт нотолгоо;



- 7.2.5. Даатгалын тохиолдол бий болсныг тодорхойлох, нотлох болон даатгалын нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход шаардлагатай бусад баримт, мэдээлэл;
- 7.2.6. Даатгалын тохиолдол үүссэн нь дээрх баримтаар нотлогдсон ажил олгогч болон ажилтны хооронд аливаа хөдөлмөрийн маргаангүй тохиолдолд даатгагч шүүхийн шийдвэр шаардахгүйгээр ажил олгогчийн хүлээх хариуцлагын даатгалын нөхөн төлбөрийг шийдвэрлэнэ.
- 7.2.7. Даатгагч нь даатгалын тохиолдол нотлогдож байх үед даатгуулагчийг хүндрүүлэх, олж авах боломжгүй, бэрхшээлтэй бичиг баримт нотолгоо нэмж шаардахгүйгээр нөхөн төлбөрийг олгоно.

### 7.3. НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ ХУГАЦАА, ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

- 7.3.1. Даатгагчийн нөхөн төлбөр хариуцсан ажилтан нөхөн төлбөрийн баримтуудыг бүрэн хүлээн авч, энэ тухай баримт хүлээлгэн өгсөн өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор нөхөн төлбөрийг олгоно.
- 7.3.2. Даатгагч гэрээнд тохирсон хугацаанд нөхөн төлбөр олгоогүй нөхцөлд олгогдох нөхөн төлбөрийн дүнгээс 0.5 хувийн алдангийг хугацаа хэтрүүлсэн хоног тутам тооцож даатгуулагчид нөхөн төлнө.
- 7.3.3. Даатгагч нөхөн төлбөртэй холбоотой нэмэлт баримт бичиг, тодруулга шаардлагатай тохиолдолд гэрээний ерөнхий нөхцөлийн 7.3.1-т заасан хугацааг ажлын 22 хоног хүртэл хугацаагаар сунгаж болно.
- 7.3.4. Энэхүү гэрээний ерөнхий нөхцөлийн 6.4.4 болон 6.4.7-д заагдсан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хожимдуулсан тохиолдолд даатгуулагч нөхөн төлбөр нэхэмжлэх эрхээ алдах бөгөөд тэрээр хүндэтгэн үзэх шалтгаантай байсан гэдгээ нотолсноор хугацааг сэргээнэ.

### 7.4. ТӨЛБӨР НЭХЭМЖЛЭХ ЭРХ ШИЛЖҮҮЛЭЛТ/SUBROGATION/

- 7.4.1. Монгол Улсын Даатгалын тухай хуулийн 8.7, Иргэний хуулийн 443.7-д тус тус заасныг үндэслэн даатгагч нөхөн төлбөрийг олгосон нөхцөлд буруутай этгээдээс төлбөр нэхэмжлэх даатгуулагчийн эрх нь даатгалаар олгогдсон нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарсан зардлын хэмжээгээр даатгагчид шилжинэ.
- 7.4.2. Даатгалын нөхөн төлбөрийг зохих журмын дагуу олгосноос хойш Даатгуулагч гарсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн тохиолдолд Даатгуулагч нь олгогдсон нөхөн төлбөрийг үл маргах журмаар даатгагчид шилжүүлнэ.
- 7.4.3. Даатгагч нь даатгалын тохиолдолд даатгуулагч, түүний ажилтны буруутай үед хохирлын нөхөн төлбөрийг буруутай этгээдээс эргүүлэн нэхэмжлэх эрхээс татгалзана.
- 7.4.4. Даатгалын тохиолдолд даатгуулагчаас өөр бусад гуравдагч этгээд буруутай байх тохиолдолд даатгагч хохирлын нөхөн төлбөрийг төлөхөд буруутай этгээдээс хохирлыг эргүүлэн төлөх гэрээ хэлцэл хийх, гарын үсэг зурахгүй байх нь даатгагчаас нөхөн төлбөр төлөх үүргээ хойшлуулах, татгалзах үндэслэл болохгүй.

### 7.5. АЛИВАА ТОМ ХЭМЖЭЭНИЙ ОСОЛ, ДААТГАЛЫН ТОХИОЛДЛЫН ҮЕД

- 7.5.1. Даатгагч шаардлагатай гэж үзсэн тохиолдолд (аливаа томоохон хэмжээний ослын үед) талууд зохих мэргэжлийн байгууллагуудтай хамтран хохирлын шалтгаан, хэмжээг тогтоох хамтарсан комисс томилон ажиллуулах ба комиссын бүрэлдэхүүнд даатгалын мэргэжилтэн, инженер-техникийн мэргэжилтэн, даатгуулагч байгууллагын төлөөлөгч байхаас гадна шаардлагатай бол хууль хяналт, гал, ус цаг уурын албаны төлөөлөгч зэрэг холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулж болно.
- 7.5.2. Хамтарсан комисс даатгалын тохиолдлын шалтгаан, хохирлын хэмжээг газар дээр нь шалган шинжлэн судалж, хохирлын шалтгааныг тогтоох зорилго бүхий даатгалын тохиолдлыг баталгаажуулах актыг үйлдэнэ. Хавсралт ...-н дагуу
- 7.5.3. Даатгагч нь олон ажилтныг хамарсан аюулт үзэгдэл, хордлого, угаартах, цахилгаан хүчдэлд цохиулах гэх мэт үйлдвэрийн ослын үед даатгагчаас хохирлыг бууруулах, ажилтны амь насыг аврах, эмнэлгийн түргэн тусламж хугацаа алдалгүй авахад хамтран ажиллаж эрсдэлийг бууруулах арга хэмжээг өөрийн зардлаар авна.
- 7.5.4. Ажилтны амь насанд аюул учруулсан осол аваарын үед ажилтны амь насыг аврах, хохирлыг бууруулахаар авсан арга хэмжээний зардалд 7.5.3-д заасны дагуу Ажил олгогчийн хариуцлагын даатгалын гэрээний дагуу осолд өртсөн ажилтан тус бүрд 2 сая /Хоёр сая/ хүртэл хэмжээгээр төлбөрийг баримтын дагуу тооцож Даатгагчаас нөхөн төлнө.





7.5.5. Том хэмжээтэй аюул ослоос үүдэн учирсан хохирлыг нөхөн төлсөн үед Талууд хэлэлцэн тохирч даатгалын үнэлгээг нэмэлт хураамж төлж сэргээж болно.

## **НАЙМ. ЕРӨНХИЙ ХАСАЛТ ХЭСЭГ**

- 8.1. Даатгалын зүйл, даатгалын тохиолдлын талаар даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн;
- 8.2. Даатгалын гэрээнд заагдаагүй эрсдэл, даатгалын үйлчлэх хүрээнээс гадуур учирсан хохирол;
- 8.3. Хохирол учирсан нь энэхүү гэрээний ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ-ийн 5.3 заасан даатгалын тохиолдлын шинжийг хангаагүй;
- 8.4. Даатгуулагчийн ажилтанд хохирол учирсан талаар даатгагч болон эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэн шалгуулаагүй, нотлох боломжгүй болон бусад шалтгаанаар хохирол учирсан шалтгаан тогтоогдоогүй, тодорхой бус байх, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох боломжгүй байх;
- 8.5. Нөхөн төлбөрийн баримтуудыг хүлээлгэж өгөх, нөхөн төлбөрийн нэхэмжлэлийн хүлээлгийн хугацаа дуусгавар болсноос хойш нөхөн төлбөрийн нэхэмжлэл хүргүүлсэн;
- 8.6. Даатгуулагчийн ажилтан согтууруулах, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн үед учирсан хохирол;
- 8.7. Даатгуулагчийн ажилтан гэмт хэрэг үйлдэх үед болон санаатайгаар өөрийн биед учруулсан, амиа хорлох оролдлого хийсэн, амиа хорлосон үед учирсан хохирол;
- 8.8. Даатгуулагчийн ажилтны нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, сэтгэл санаанд учирсан хохирол;
- 8.9. Мэргэжлийн спортын уралдаан тэмцээн/сонирхогчийн сагсан бөмбөг, гар бөмбөг зэрэг байгууллагаас зохиодог спортын уралдаан тэмцээн үүнд хамаарахгүй/, мөн бүхий л дотоод шаталтын хөдөлгүүртэй тээврийн хэрэгслээр уралдаан тэмцээнд оролцсон, уулын спорт, агаарын спорт болон шүхрийн спортод оролцсоны улмаас үүссэн осол гэмтэл;
- 8.10. Ан ав хийх үед учирсан хохирол;
- 8.11. Төрөлт, зулбалт, үр хөндөлт зэрэг жирэмслэлттэй холбоотой хохирол; Гэнэтийн ослоос үүдэлтэй зулбалт уг хасалтад хамаарахгүй.
- 8.12. Бэлгийн замын бүх төрлийн өвчлөл, ДОХ/ХДХВ-ийн халдвартай холбоотой хохирол;
- 8.13. Тэнгисийн, агаарын болон зэвсэгт хүчний үйл ажиллагаанд оролцсоноос үүдэн гарсан хохирол;
- 8.14. Сальют, пүүжин, хонгио, сум, дарь ашиглалт, тээвэрлэлттэй холбоотой учирсан хохирол;
- 8.15. Дайн, дайн бүхий байдал, зэвсэгт бослого, байлдааны зэвсэг хэрэглэх, үймээн самуун, террорист үйл ажиллагаа, бослого, ажил хаялт, нийгмийн эмх замбараагүй байдал, төрийн захиргааны байгууллагын акт шийдвэр, улс төрийн тэмцэлд оролцсон, цөмийн дэлбэрэлт, цацраг идэвхт бодис буюу туяаны хордлого;
- 8.16. Даатгуулагч даатгалын хураамжийг даатгагчаас олгосон нэмэлт хугацаа хэтэрсэн тохиолдолд төлөөгүй байх үед учирсан хохиролд тус тус даатгагч даатгалын нөхөн төлбөр олгох үүргээс бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөгдөнө.

## **ТУСГАЙ НӨХЦӨЛ**

### **ЗҮЙЛ НЭГ. АЖИЛ ОЛГОГЧИЙН ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ**

#### **НЭГ. НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР**

- 1.1 Энэхүү гэрээнд хэрэглэсэн “Ажил олгогчийн хариуцлагын даатгал”-ын нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.
  - 1.1.1 **ДААТГАЛЫН ЗҮЙЛ:** Хөдөлмөрийн тухай хууль, түүний 97-р зүйл, бусад хууль тогтоомжийн дагуу ажилтны өмнө хүлээх даатгуулагчийн хариуцлага, даатгуулагч ажилтны хооронд үүсэн хөдөлмөрийн харилцаатай холбоотой маргааны улмаас ажилтанд нөхөн төлбөр олгох тухай шүүхийн шийдвэрээс үүссэн хариуцлага;
  - 1.1.2 **ДААТГАЛЫН ЭРСДЭЛ:** Хөдөлмөрийн тухай хууль, түүний 97-р зүйл болон бусад хууль тогтоомжийн дагуу ажилтны өмнө хүлээх даатгуулагчийн үүрэг, хариуцлага, даатгуулагч ажилтны хооронд үүсэн хөдөлмөрийн харилцаатай холбоотой маргааны улмаас ажилтанд нөхөн төлбөр төлөх тухай шүүхийн шийдвэр гарсан тохиолдол болон Ажил олгогч, ажилтан, түүний төлөөлөл хүлээн зөвшөөрсөн үед даатгуулагчид төлөвлөөгүй зардал учрах эрсдэлийг ойлгоно;



- 1.1.3 **ДААТГАЛЫН ТОХИОЛДОЛ:** ЗҮЙЛ НЭГ-н 1.1.2 т заасан эрсдэлийн улмаас даатгуулагчид учирсан төлөвлөөгүй зардлын эрсдэлийн хохирол, үр дагаврыг энэхүү даатгалын гэрээний дагуу Даатгагч харнууцан арилгах үүрэг хүлээх, нөхөн төлөхөөр тохиролцсон болзол бүрдэхийг;
- 1.1.4 **АЖЛЫН ЦАГ:** Ажлын цаг, ажилдаа ирэх очих, илүү цаг хөдөлмөрлөх, гадаад, дотоодод томилолтоор ажиллах, гадуур ажиллах, ажил олгогчоос албан ёсоор зохиосон арга хэмжээнд ирэх очих хугацааг ойлгоно.
- 1.1.5 **БҮХ ТӨРЛИЙН ГЭНЭТИЙН ОСОЛ:** Урьдчилан таамаглах боломжгүй, гэнэтийн шинжтэй тохиолдлоос-ажилтны амь-нас эрсдэх, эрүүл-мэнд-хохирох, гэмтэх, бэртэх, хөдөлмөрлөх чадварт нөлөөлөх бүх төрлийн аюулт тохиолдол, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, гаднын нөлөө, мал амьтны нөлөө, бүх төрлийн тээврийн хэрэгслээр зорчих үеийн осол, хорхой шавьжинд хатгуулах, халтирах гулгах, унах, бэртэх, түлэгдэх, цохиулах, ахуйн осол, бүх төрлийн хордлого, угаартах, цахилгааны хүчдэлд цохиулах, өндрөөс ойчих, живэх, химийн бодист түлэгдэх, хордох, халдлагад өртөхийг ойлгоно;
- 1.1.6 **ХАМТАРСАН КОМИСС:** Даатгуулагч, даатгагчаас томилж даатгалын тохиолдлыг шалгах баталгаажуулахаар томилсон ажлын хэсгийг ойлгоно.
- 1.1.7 **АГААРААР ЗӨӨН ТЭЭВЭРЛЭХ ЗАРДАЛ:** Тухайн ажилтны амь нас, эрүүл мэнд нь эрсдэж болзошгүй нөхцөл байдал үүссэн үед эмчийн зааварчилгаагаар зайлшгүй шаардлагатай тохиолдолд яаралтай эмнэлэгт хүргэх зардлыг ойлгоно.

## **ХОЁР. НӨХӨН ТӨЛБӨРИЙН ТООЦООЛОЛ**

- 2.1 Даатгуулагчийн ажилтны амь нас, эрүүл мэндэд Тусгай нөхцөлийн Зүйл нэг-н 2.2 –т заасан эрсдэлээс учирсан хохирлыг хөдөлмөрийн чадвар алдалтын хугацаа болон хувь хэмжээнээс хамааран доорх хэмжээгээр нөхөн төлбөр олгоно.

### **Хүснэгт 4 Ажил олгогчийн хариуцлагын даатгалын нөхөн төлбөр тооцоолол**

|   | <b>Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь</b>                                      | <b>Олгох нөхөн төлбөрийн хэмжээ</b> |
|---|--|-------------------------------------|
| 1 | 30% хүртэл   | 5 сарын цалингийн нийлбэр           |
| 2 | 31-50 %  | 7 сарын цалингийн нийлбэр           |
| 3 | 51-70%   | 9 сарын цалингийн нийлбэр           |
| 4 | 71% -иас дээш  | 18 сарын цалингийн нийлбэр          |
| 5 | Нас барах  | 36 сарын цалингийн нийлбэр          |
| 6 | Хуулийн бусад заалтаар хөдөлмөрийн маргаанаас нөхөн олговор төлөх хариуцлага | Шүүхийн шийдвэрийн дүнгээр          |

- 2.2 Ажил олгогчийн хариуцлагын даатгалаар Хөдөлмөрийн тухай хууль, түүний 97-р зүйл болон бусад хууль тогтоомжийн дагуу ажилтны өмнө хүлээх даатгуулагчийн үүрэг, хариуцлага, даатгуулагч ажилтны хооронд үүсэн хөдөлмөрийн харилцаатай холбоотой маргааны улмаас ажилтанд нөхөн төлбөр төлөх тухай шүүхийн шийдвэр гарсан тохиолдол, ажилтан ажлын цагаар үйлдвэрлэлийн осолд орох, хурц хордлогод орох, угаартах, химийн бодист түлэгдэх, хордох, цахилгааны хүчдэлд цохиулах, өндрөөс унах, живэх, дарагдах зэрэг бүх төрлийн гэнэтийн осолд өртөх, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс хөдөлмөрийн чадвар түр болон хагас, бүрэн алдах, нас барах тохиолдолд ажилтанд Хүснэгт 4-т заасны дагуу нөхөн төлбөрийг төлнө.
- 2.3 Ажилтан дээр дурдсан энэхүү тусгай ЗҮЙЛ НЭГ-н 2.2-т заасан ослоос хөдөлмөрийн чадвар алдалтын зэрэг тогтоолгож нөхөн төлбөр авсан боловч цаашид эмчилгээ авалгүй нас барах, уг гэмтэл бэртэл нь цаашид амь насаа алдах шалтгаан болсон тохиолдолд Даатгагчаас даатгалын үнэлгээний үлдэгдлийг нэмж төлнө. Ийнхүү урьд нь олгогдсон болон нэмж олгох нөхөн төлбөрийн нийт дүн нь тухайн ажилтны 36 сарын дундаж цалингийн нийлбэрээс хэтрэхгүй.
- 2.4 Ажил олгогчийн хариуцлагын даатгалын “Хөдөлмөрийн тухай хууль, түүний 97-р зүйл болон бусад хууль тогтоомжийн дагуу ажилтны өмнө хүлээх даатгуулагчийн үүрэг, хариуцлага, даатгуулагч ажилтны хооронд үүсэн хөдөлмөрийн харилцаатай холбоотой маргааны улмаас ажилтанд нөхөн төлбөр төлөх тухай шүүхийн шийдвэр гарсан тохиолдлын зохицуулалт нь” гэрээний Ерөнхий нөхцөлийн 5.2 болон 5.4 д заасан тодорхойлолтод хамаарахгүй.





- 2.5 Даатгуулагчийг ажилтны өмнө хүлээх хариуцлагын Хөдөлмөрийн тухай хууль, Иргэний хуулийн дагуу ажилтан, гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагаас чөлөөлүүлэх зорилгын хүрээнд нөхөн төлбөрийг Даатгуулагч буюу ажил олгогчид шууд шилжүүлнэ.
- 2.6 Хөдөлмөрийн харилцаатай холбоотой маргааны улмаас даатгуулагч нь ажилтанд нөхөн олговор төлөх хариуцлага хүлээх тохиолдолд шүүхийн шийдвэрийг үндэслэн даатгагчаас нөхөн төлбөр олгоно.
- 2.7 Ажилтан энэхүү гэрээний дагуу гэнэтийн ослын даатгал, эмчилгээний зардлын даатгалаас нөхөн төлбөр авсан нь Ажил олгогчийн хариуцлагын даатгалаар нөхөн төлбөр төлөхгүй байх нөхцөл болохгүй.
- 2.8 Ажилтан нь үйлдвэрлэлийн ослын улмаас бэртэж ажилтны амь насыг яваралтай авран хамгаалах нөхцөл байдалд орсон буюу эмчийн заавраар зайлшгүй агаараар тээвэрлэх нөхцөл байдал бий болсон бол даатгагчийн эмчид мэдэгдэж зөвшөөрөл авсаны дагуу агаараар зөөн тээвэрлэх зардлыг гэрээний хугацаанд нийт 10,000,000 төгрөг хүртэлх хэмжээгээр нөхөн төлнө. Нэг жилд 3-аас илүү тохиолдлыг даатгагч хариуцахгүй.
- 2.9 Даатгалын нэг удаагийн тохиолдолд нэг нэхэмжлэлд хүлээх Даатгуулагчийн өөрийн хүлээх хариуцлага 00 Тэг төгрөг байна.

#### **ГУРАВ. ХАСАЛТ ХЭСЭГ**

- 3.1. Дараах нөхцөлөөс учирсан хохиролд даатгагч нөхөн төлбөр төлөхгүй.

Үүнд:

- 3.1.1. Даатгуулагчийн ажилтан ажил олгогчийн шийдвэргүйгээр үндсэн үүрэгт ажлаасаа өөр ажил гүйцэтгэж байх үед, ажлын бус өдөр/ цагт учирсан хохирол;
- 3.1.2. Даатгуулагчийн ажилтан тээврийн хэрэгслийг жолоодох эрхгүй, хөдөлгөөнд оролцуулахыг хориглосон тээврийн хэрэгсэл хөдөлгөөнд оролцуулснаас учирсан хохирол;
- 3.1.3. Даатгуулагч хариуцлага хүлээхгүй нөхцөлд буюу ЗҮЙЛ НЭГ-н 1.1.3-т заасан даатгалын тохиолдол бүрдээгүй үед ажилтан гэнэтийн осолд орсон, нас барсан нөхцөлд даатгагч Ажил олгогчийн хариуцлагын даатгалаар нөхөн төлбөр төлөхгүй.
- 3.1.4. Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээгүй ажилтанд учирсан хохирол;

#### **4. ДӨРӨВ. НӨХӨН ТӨЛБӨРИЙН НЭХЭМЖЛЭЛ**

- 4.1. Ажил олгогчийн хариуцлагын даатгалаар нэхэмжлэл гаргахад энэхүү гэрээний **ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ 7.2-т** дурдсан баримт материалаас тухайн хэрэгт хамааралтайг бүрдүүлэхээс гадна дараах зүйлсийг бүрдүүлнэ. Үүнд:
  - 4.1.1. Ажилтан осол аюулд өртсөн, мэргэжлээс хамаарах өвчлөлөөр өвчилсөн нь даатгуулагч Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээх нөхцөл мөн эсэхийг магадалж гаргасан даатгуулагчийн хурлын шийдвэр, тушаал;
  - 4.1.2. Хөдөлмөр магадлах комиссын акт;
  - 4.1.3. Ажилтан нас барсан тохиолдолд нас барсны гэрчилгээ хуулбар хувь;
  - 4.1.4. Ар гэрийнхнээс гаргасан өргөдөл гомдлын хуулбар хувь;
  - 4.1.5. Даатгалын тохиолдлыг баталгаажуулсан хамтарсан комиссын маягт;
  - 4.1.6. Хөдөлмөрийн гэрээний маргаанаас үүссэн даатгалын тохиолдолд шүүхийн шийдвэрийн хуулбар хувь;
  - 4.1.7. Хохирлыг бууруулахаар авсан арга хэмжээний зардлын баримт, нотлох баримтууд;
- 4.2. Хүний амь нас эрсдээгүй, халтгирах гулгах, мал амьтны нөлөөлөл зэрэг ахуйн ослын үед (ажлын байрнаас гадуур болсон осол аюул, ажилтан томилолтоор ажиллах хугацаанд болсон осол, ажлаас буцах, ажилдаа ирэх замд болсон ослыг тодорхойлоход) талуудын хамтарсан комиссын дүгнэлтийг үндэслэн Хавсралт №3 Даатгалын тохиолдлыг баталгаажуулах акт, эсвэл Хавсралт №4 дагуу үйлдвэрээс гаргасан Осол, осолд дөхсөн тохиолдлын дүн, шинжилгээний мэдээ, тайлангийн аль нэгийг үндэслэн тогтоох бөгөөд эрх бүхий байгууллагын шийдвэр, нотолгоо баримтыг шаардахгүйгээр Даатгагчаас нөхөн төлбөр төлнө.

#### **ЗҮЙЛ ХОЁР. ГЭНЭТИЙН ОСЛЫН ДААТГАЛ**

#### **НЭГ. НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР**



1.1 **ДААТГАЛЫН ЗҮЙЛ:** Энэхүү гэрээний Хавсралт 1-т нэр дурдсан Даатгуулагчийн ажилтны амь нас, эрүүл мэнд нь даатгалын зүйл байна.

1.2 **БҮХ ТӨРЛИЙН ГЭНЭТИЙН ОСОЛ:** Бүх төрлийн гэнэтийн осол гэдэгт урьдчилан таамаглах боломжгүй, гэнэтийн шинжтэй тохиолдлоос ажилтны амь нас эрсдэх, эрүүл мэнд хохирох, гэмтэх, бэртэх, хөдөлмөрлөх чадварт нөлөөлөх бүх төрлийн аюулт тохиолдол, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, гаднын нөлөө, мал амьтны нөлөө, бүх төрлийн тээврийн хэрэгслээр зорчих үеийн осол, хорхой шавьжинд хатгуулах, халтирах гулгах, унах, бэртэх, түлэгдэх, цохиулах, ахуйн осол, бүх төрлийн хордлого, угаартах, цахилгааны хүчдэлд цохиулах, өндрөөс-ойчих, живэх, химийн бодист түлэгдэх, хордох, халдлагад өртөхийг ойлгоно; Ажилтан гэнэтийн ослоос бус, далд хэлбэрийн өвчний шалтгаант зүрх хаагдах, цус харвах, хурц хордлогоос бусад шалтгаантай нойр булчирхайн хурц үрэвсэл, цус алдсанаас амь насаа алдах эрсдэл энэхүү гэрээний дагуу даатгах гэнэтийн осолд хамаарахгүй.

## **ХОЁР. ДААТГАЛЫН ЭРСДЭЛ, ХАМРАХ ХУГАЦАА, ЗОРИЛГО**

2.1 Энэхүү гэрээний даатгалын хамгаалалт нь ажилтан 24 цагийн туршид үндсэн ажил үүргээ гүйцэтгэх үед болон гүйцэтгээгүй байх үед, дотоод, гадаадад томилолтоор ажиллах үед үйлчлэх бөгөөд ЗҮЙЛ ХОЁР 1.2-т заасан БҮХ ТӨРЛИЙН ГЭНЭТИЙН ОСОЛ, нас баралтын эрсдэлээс учирсан үр дагавар, хохирлыг нөхөн төлөх зорилготой.

## **ГУРАВ. БУСАД**

3.1 **ДААТГАЛ ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ:**

Ажил үүргээ гүйцэтгэж байх үед болон гүйцэтгээгүй байх үед 24 цагийн турш үйлчилнэ.

3.2 **ДААТГУУЛАГЧИЙН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА:**

Байхгүй

3.3 **ГАЗАР НУТГИЙН ХЯЗГААР:**

Монгол улс болон дэлхийн бусад оронд томилолтоор ажиллах, аялах хугацаанд 24 цагийн хугацаанд хүчинтэй үйлчилнэ.

3.4 Энэхүү ЗҮЙЛ ХОЁР-т заасан гэнэтийн ослын даатгалаар нөхөн төлбөр авах нь ажилтан энэхүү гэрээний бусад зүйл, хамгаалалтаар нөхөн төлбөр авахгүй байх нөхцөл болохгүй.

## **ДӨРӨВ. НӨХӨН ТӨЛБӨРИЙН ТООЦООЛОЛ**

4.1 Даатгуулагчийн ажилтны амь нас, эрүүл мэндэд энэхүү тусгай нөхцөлийн 1.2-т заасан БҮХ ТӨРЛИЙН ГЭНЭТИЙН ОСОЛ-оос учирсан хохирлыг хөдөлмөрийн чадвар алдалтын хугацаа болон хувь хэмжээнээс хамааран Хүснэгт 5-д заасан хэмжээгээр нөхөн төлбөр төлнө.

4.2 Нөхөн төлбөр олгохдоо ажилтны листийн /эмнэлгийн хуудас/хоногоор тооцож Хүснэгт 5-д заасан хувь хэмжээгээр нөхөн төлбөрийг олгоно.

4.3 Хэрэв ажилтны лист сунгагдсан тохиолдолд анх олгогдсон листийн хугацаан дээр сунгасан хугацааг нэмж нэгтгэн нийлбэр нь хамаарах шатлалын нөхөн төлбөрийн хувь хэмжээгээр тооцож анхны листийн нөхөн төлбөрийг хасаж үлдэгдлийг олгоно.

4.4 Хэрэв ажилтны хөдөлмөрийн чадвар түр алдалтын нөхцөлөөр нөхөн төлбөр авсан бөгөөд гэмтэл бэртэл цаашид хөдөлмөрийн чадвар алдалтын зэрэг тогтоолгох, амь насаа алдахад хүргэх тохиолдолд олгогдох нөхөн төлбөрийн дүнгээс урьд олгогдсон нөхөн төлбөрийг хасаж зөрүүг олгоно.

4.5 **Хүснэгт 5 Гэнэтийн ослын даатгалын нөхөн төлбөр төлөх тооцоолол**

| Хөдөлмөрийн чадвар түр алдалтын хугацаа / ажлын өдрөөр тооцно/ | Даатгалын үнэлгээнээс тооцож олгох нөхөн төлбөрийн хувь хэмжээ / 10,000,000₮ / |
|--|--|
| 1-15 ХЧ алдсан ажлын өдөр                                      | 0,7 % / өдрийн 70 000төг х ХЧ алдсан хоног/                                    |
| 16-30 алдсан ажлын өдөр  | 0,5% / ХЧ алдсан ажлын хоног х 50 000төг/                                      |
| 31-45 алдсан ажлын өдөр  | 0,5%/ ХЧ алдсан ажлын хоног х 50 000төг/                                       |
| 46-60 алдсан ажлын өдөр  | 0,5% / ХЧ алдсан ажлын хоног х 50 000төг/                                      |
| 61-75 алдсан ажлын өдөр  | 0,5% / ХЧ алдсан ажлын хоног х 50 000төг/                                      |
| 76-90 алдсан ажлын өдөр  | 0,5% / ХЧ алдсан ажлын хоног х 50 000төг/                                      |



|   |   |
|---|---|
| 91-дээш ажлын өдөр                      | 50% / 5,000,000/  |
| <b>Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь</b> | <b>Даатгалын үнэлгээнээс тооцож олгох нөхөн төлбөрийн хувь хэмжээ / 10,000,000₮ /</b> |
| 30% хүртэл                              | 5,500,000   |
| 31-50 %                                 | 6,000,000   |
| 51-70%                                  | 7,000,000   |
| 71% -иас дээш                           | 8,000,000   |
| Нас барах                               | 10,000,000  |

- 4.6 Талууд хохирол учирсан талаар нарийвчлан шалгах шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн этгээдээр шинжилгээ хийлгэх эрхтэй.
- 4.7 Нэг ажилтанд олгох нөхөн төлбөрийн хэмжээ тухайн ажилтны даатгалын нийт үнэлгээнээс хэтрэхгүй.
- 4.8 Даатгалын нэг удаагийн тохиолдолд нэг нэхэмжлэлд хүлээх Даатгуулагчийн өөрийн хүлээх харнуцлага 00 /Тэг/ төгрөг байна.

#### **ТАВ. НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХГҮЙ НӨХЦӨЛ**

- 5.1 Ажилтан даатгалд хамрагдахаас өмнө өртсөн осол гэмтэл;
- 5.2 Ажилтан согтуурсан, мансуурсан үед осолд өртсөн;
- 5.3 Даатгалын гэрээнд нэр нь дурдагдаагүй ажилтан; /Ажил олгогчийн даатгал үүнд хамаарахгүй/
- 5.4 Ердийн болон халдварт өвчин, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс хөдөлмөрийн чадвар алдсан, тахир дутуугийн зэрэг тогтоолгосон, нас барсан тохиолдол;
- 5.5 Гэнэтийн өвчлөлийн шалтгаанаас зүрх хаагдах, цус харвах, хурц хордлогоос бусад нөхцөлөөс үүссэн нойр булчирхайн хурц үрэвсэл, цус алдах, халдварт өвчин, ковид 19, хавдараас ажилтан нас барах;

#### **ЗУРГАА. НӨХӨН ТӨЛБӨРИЙН НЭХЭМЖЛЭЛД**

6. Даатгалын тохиолдлын нөхөн төлбөрт даатгагчаас зааварчилсаны дагуу дор дурдсан баримтаас аль шаардлагатай бүрдүүлнэ. Үүнд:
- 6.1 Даатгуулагчийн албан хүсэлт
- 6.2 Ажилтны өргөдөл /дансны дугаар бүхий/
- 6.3 Иргэний үнэмлэхийн хуулбар
- 6.4 Боломжтой тохиолдолд осол, гэмтлийг нотлох фото зураг
- 6.5 Хөдөлмөрийн чадвар алдалтын хугацаа, хувь хэмжээг тогтоосон эмнэлэг-хөдөлмөр магадлах комиссын акт, эмнэлгийн хуудас/лист, эмчийн онош бүхий эмнэлгийн магадлагаа, эм тариа худалдан авсан баримт, эмнэлгийн үйлчилгээ, төлбөр төлсөн баримт зэрэг эдгээрээс аль шаардлагатайг бүрдүүлнэ.;
- 6.6 Даатгагчаас шаардлагатай гэж үзсэн тохолдолд хамтарсан комиссоос баталгаажуулсан Даатгалын тохиолдлыг баталгаажуулах акт /Хавсралт №3 дагуу/, эсвэл үйлдвэрээс гаргасан осол болон осолд дөхсөн тохиолдлын дүн шинжилгээний мэдээ, тайлан /Хавсралт №4 дагуу/;
- 6.7 Ажилтан нас барсан тохиолдолд нас барсны гэрчилгээ, нөхөн төлбөр авах эрхтэй этгээдийн иргэний үнэмлэхийн хуулбар, өв залгамжлах эрхийг баталгаажуулсан баримт нотолгоо;

#### **ЗҮЙЛГУРАВ. ЭРҮҮЛ МЭНД, ЭМЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ДААТГАЛ**

#### **НЭГ. ГЭРЭЭНД ХЭРЭГЛЭГДЭХ НЭР ТОМЬЁО**

- 1.1 Энэхүү гэрээнд хэрэглэсэн Эмнэлэг эмчилгээний даатгалын нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.
- 1.1.1 **ЕРДИЙН ӨВЧИН:** Архаг хууч өвчнөөс бусад шалтгааны улмаас ажилтны бие физиологи гарсан эмчлүүлэх шаардлагатай өөрчлөлтийг хэлнэ.
- 1.1.2 **АРХАГ ХУУЧ ӨВЧИН:** Аливаа өвчин, бэртэл гэмтлийн улмаас ажилчид тухайн өвчний шинж тэмдэг илрэн эмчийн зөвлөгөө авч байсан, онош тогтоолгосон, эмчийн заавраар эм тариа хэрэглэж эмчилгээ хийлгэж байсан, даатгалын гэрээ хийхээс өмнө тухайн өвчний талаар ажилтан мэдэж байсан тохиолдол,
- 1.1.3 **БҮХ ТӨРЛИЙН ГЭНЭТИЙН ОСОЛ:** Гэрээний хасалт хэсэгт зааснаас бусад бүх төрлийн гэнэтийн осол аюул;





- 1.1.4 **ГЭНЭТИЙН ӨВЧЛӨЛ:** Гэнэтийн өвчин гэдэгт урьд өмнө нь илэрч байгаагүй бөгөөд гэнэтийн байдлаар бие эрхтэнд өөрчлөлт өгөх доорх өвчлөлүүдийг оруулна. Үүнд:
- ✓ Мухар олгойн хурц түгжрэл болон түүний архаг үрэвслийн сэдрэлт
  - ✓ Гэдэсний хурц түгжрэл
  - ✓ Хоол боловсруулах эрхтний цооролт, түлэгдэлт
  - ✓ Өмнө оношлогдож байгаагүй эмгэгээс болсон тархины цус харвалт /hemorrhagic stroke-гемморрагийн инсульт/
  - ✓ Хурц буглаат өвчнүүд /хатги, мундас, идээт бээр/
  - ✓ Хорт ургамал, шавьжинд хордох
  - ✓ Бүх төрлийн хордлого
  - ✓ Өмнө оношлогдож байгаагүй эмгэгээс болсон цус алдалт
  - ✓ Зүрх хаагдах
- 1.1.5 **НЭХЭМЖЛЭЛ:** Даатгалын гэрээний нөхцөлийн дагуу олгогдох нөхөн төлбөр авах боломжтой, даатгуулагчийн нөхөн төлбөр хүссэн албан ёсны хүсэлт;
- 1.1.6 **ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭХ:** Ажилтан эмчилгээний өмнө, эмчилгээний туршид болон эмчилгээний дараа эмнэлэгт хэвтэн шаардлагатай эмчилгээ хийлгэх;
- 1.1.7 **ӨӨРИЙН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА:** Даатгалын тохиолдлоос үүссэн хохиролд даатгагчийн олгох нөхөн төлбөрөөс хасагдах хэмжээ буюу даатгуулагчийн хариуцах мөнгөн төлбөрийн хэмжээг
- 1.1.8 **ОНОШИЛГОО:** Өвчнийг оношлох эмгэг судлал, лаборатори, рентген зураг, зүрхний бичлэг, компьютер томограф, эмнэлгийн дүрс бичлэг хийх техникийн тестүүд болон эмчийн шинжилгээний хариу тайлбар;
- 1.1.9 **ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА:** Даатгалын гэрээнд тусгагдсан хугацаа;
- 1.1.10 **ЭМЧИЛГЭЭ:** Зайлшгүй тохиолдлын улмаас оношилгоо, эмчилгээ, мэс ажилбар хийлгэх болон эмнэлгийн үйлчилгээ шаардлагатай тохиолдол;
- 1.1.11 **ЭМЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ:** Зайлшгүй төлөх шаардлагатай, гэрээнд тусгагдсан эмчилгээ, түүнтэй холбогдон гарах зардлууд болон мэс заслын зардлууд;
- 1.1.12 **ТҮРГЭН ТУСЛАМЖ:** Гэнэтийн гэмтэл, өвчин эсвэл 24 цагийн турш эмнэлгийн тусламж аваагүйгээс өвчин нь хүндэрсэн өвчтөний бие махбод, эд эрхтэн, амь насанд аюул учирч болзошгүй үед үзүүлэх түргэн тусламж;
- 1.1.13 **ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ:** Даатгалд хамрагдсан ажилтны дэлгэрэнгүй мэдээлэл болон хураамжийн тооцооллыг тусгасан гэрээний хавсралт 1
- 1.1.14 **ДААТГАЛД ХАМААРАХГҮЙ НӨХЦӨЛҮҮД:** Энэхүү гэрээнд хамрагдахгүй өвчнүүд, эмчилгээ болон тэдгээртэй холбоотой гарах зардлууд. Эдгээр нь энэхүү гэрээний хамаарахгүй нөхцөл хэсэгт орсон.
- 1.1.15 **ЭМНЭЛЭГ:** Тухайн улс оронд эмчилгээний эсвэл мэс заслын эмчилгээ хийх лицензтэй эмнэлэг;
- 1.1.16 **ЭМНЭЛГИЙН БАЙР БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭ:** Ажилтныг эмнэлэгт хэвтэхийг зөвшөөрсөн эсвэл өдрийн цагаар эмчлүүлэгчээр бүртгэгдсэн үед эмчийн зөвлөсний дагуу шаардагдах бүх эмнэлгийн эмчилгээнүүд;
- 1.1.17 **ӨВЧИН:** Даатгалын гэрээний хамаарахгүй нөхцөлөөс бусад даатгалын гэрээний хугацаан дахь ажилтны эрүүл мэндийн байдал болон эмчээс эрүүл мэндийн тусламж авах шаардлагатай тохиолдлууд;
- 1.1.18 **ЭМНЭЛГИЙН ШААРДЛАГАТАЙ ЭМЧИЛГЭЭ:** Ажилтан дараах эмчилгээ, мэс заслын үйлчилгээг авна. Үүнд:
- a. Оношилгоо шинжилгээгээр зайлшгүй эмчлэх, мэс засал хийх шаардлагатай өвчлөл;
  - b. Эмчилгээг эмнэлгийн зөвшөөрөгдсөн ерөнхий практик болон мэргэжлийн хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу хийх;
  - c. Эмчилгээг туршилтын журмаар хийх болон баталгаагүй байж болохгүй;
- 1.1.19 **ДААТГАЛЫН ХУРААМЖ:** Даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг;
- 1.1.20 **ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР:** Даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид гэрээний дагуу олгох мөнгөн хөрөнгийг;
- 1.1.21 **ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГА:** Мэргэжлийн эмчийн болон эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр зайлшгүй хийгдэх шаардлагатай эмчилгээ үйлчилгээ;

## ХОЁР. ДААТГАЛЫН ЗҮЙЛ





2.1 Хавсралт 1-т заасан Даатгуулагчийн ажиллагсдын эрүүл мэнд нь даатгалын зүйл байна.

## ГУРАВ. ДААТГАЛЫН ЭРСДЭЛ, ХАМГААЛАЛТ

1.1 Ажилтанд мэргэжлээс шалтгаалах өвчин, ердийн болон халдварт өвчин, жирэмслэлтийн үеийн хүндрэл, бүх төрлийн осол, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос үүдэн учрах эмнэлэг, эмчилгээний зардлын эрсдэл; Үүнд:

- 1.1.1 Ердийн өвчлөл
- 1.1.2 Гэнэтийн өвчлөл
- 1.1.3 Мэргэжлээс шалтгаалах өвчин
- 1.1.4 Гэнэтийн ослоос үүдэлтэй эмчилгээ
- 1.1.5 Үйлдвэрлэлийн ослоос үүдэлтэй эмчилгээ
- 1.1.6 Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх
- 1.1.7 Хүлээн авах болон амбулаторын эмчилгээ
- 1.1.8 Мэс засал
- 1.1.9 Гэрээр эмчлүүлэх
- 1.1.10 Ослоос үүдсэн шүдний эмчилгээ
- 1.1.11 Жирэмсний үеийн хүндрэл
- 1.1.12 Бусад үйлчилгээ /даатгалын хамгаалалт хэсэгт заагдсан/

## ДӨРӨВ. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

- 4.1 Даатгалын хугацаанд даатгалын эрсдэлийн улмаас даатгагдсан ажиллагсдын эрүүл мэндэд хохирол учирснаас гарах эмчилгээний зардлыг даатгалын үнэлгээний хязгаарт багтаан гарсан зардлын хэмжээгээр Даатгагч нөхөн төлнө. Боломжтой тохиолдолд даатгагчийн гэрээт болон хамтран ажилладаг эмнэлгийн байгууллагад шууд төлж болно. Энэ тохиолдолд даатгагчид урьдчилан мэдэгдэж тохиролцоно.
- 4.2 Ажилтан албан томилолт болон аяллаар /30 хүртэлх хоног/ гадаадад байх хугацаанд даатгалын тохиолдол үүссэн бол эмнэлгийн байгууллагаас авсан эмнэлэг, эмчилгээний баримтын дүнгээр зардлыг ажилтанд нөхөн төлнө. Боломжтой тохиолдолд гэрээт болон хамтран ажилладаг эмнэлгийн байгууллагад шууд төлөх нөхцөлтэй байна.
- 4.3 Ажилтны нэхэмжилсэн нөхөн төлбөрийн нийт дүн үнэлгээний хязгаарт хүрч даатгуулагч гэрээний үүргээ бүрэн биелүүлсэн тохиолдолд даатгалын үнэлгээ дахин сэргэхгүй бөгөөд гэрээг дуусгавар болсон гэж үзнэ.

| №  | Даатгалын хамгаалалт  | Нэг ажилтны даатгалын нийт үнэлгээ нь 2,000,000₮ байна. |
|----|---|---|
| 1. | Мэргэжлийн эмчийн үзлэг<br>(Эмнэлэгт хэвтэлгүйгээр мэргэжлийн эмчийн үзлэг, зөвлөгөө, тусламж авах<br>Өдрийн цагаар эмнэлэгт хэвтэх, хүлээн авахад хонож эмчлүүлэх, эмнэлгийн боломж байхгүйн улмаас мэргэжлийн болон зохих зөвшөөрөлтэй эмчийн үйлчилгээ, шинжилгээ Амбулатори, Паталог, Радиологи, Химийн эмчилгээ, Физик эмчилгээ зэрэг) | 4.9-т заасан хувь хэмжээгээр нөхөн төлнө.               |
| 2. | Эмнэлэг, эмчийн заавраар хийлгэх амбулаторийн шинжилгээнүүд<br>(бактерлоги, биохими, ерөнхий шинжилгээнүүд, гормон илдэс судлал, эд эсийн судлал, хавдрын сорил гэх мэт бүх төрлийн шинжилгээнүүд)  | 4.9-т заасан хувь хэмжээгээр нөхөн төлнө.               |
| 3. | Эмнэлэг эмчийн заавраар хийгдэх тоног төхөөрөмж шаардагдах шинжилгээнүүд<br>(хэт авиа, MRI, компьютер томограф, соронзон томорграф, рентген гэх мэт)  | 4.9-т заасан хувь хэмжээгээр нөхөн төлнө.               |
| 4. | Эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх<br>(Эмчлүүлэх шаардлагатай даатгуулагч эмнэлгийн байгууллагаар хийлгэсэн эмчилгээ үйлчилгээтэй)   | 4.9-т заасан хувь хэмжээгээр нөхөн төлнө.               |



|     |  |   |
|-----|--|---|
|     | холбоотой дараах зардлууд: эмнэлгийн ор хоногийн төлбөр, төлбөрт үйлчилгээ, мэс заслын болон мэдээ алдуулалтын зардал, Мэс заслын дараах сувилгааны зардал, эм, тариа, боолт материал, бусад эмчийн бичиж өгсөн эмчилгээ үйлчилгээнд гарах зардал)   |   |
| 5.  | <b>Эмчийн жороор бичсэн эм, тариа</b>  | 4.9-т заасан хувь хэмжээгээр нөхөн төлнө.   |
| 6.  | <b>Мэс засал</b>   | 4.9-т заасан хувь хэмжээгээр нөхөн төлнө.   |
| 7.  | <b>Нойрсуулах эмчийн үйлчилгээ</b>   | 4.9-т заасан хувь хэмжээгээр нөхөн төлнө.   |
| 8.  | <b>Гэрээр эмчлүүлэх</b><br>(эмнэлэгт хэвтэх шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд гэрээр эмчлүүлэхэд шаардагдах эм тариа, боолт материал, давтан үзүүлэхэд гарах зардал, амбулаторноор хийгдсэн бүх төрлийн эмчилгээ, мэс засал, түргэн тусламжийн үйлчилгээ, эмнэлэгт авсан үйлчилгээ, нөхөн сэргээх эмчилгээ, хүлээн авахад хэвтэж эмчлүүлсэн зардал зэрэг холбогдон гарах бүх зардлууд) | 4.9-т заасан хувь хэмжээгээр нөхөн төлнө.   |
| 9.  | <b>Эмнэлгээс гарсны дараах эмчилгээ</b><br>(Даатгуулагч эмнэлгээс гарсны дараа эмчлэгч эмчийн заавраар бичиж олгосон бүх төрлийн эм тариа, боолт материалын зардал, дахин шинжлүүлэхэд гарах зардал, давтан эмчлүүлэхэд гарах зардал, эмнэлгээс гарснаас хойш хамаарна)  | Эмнэлэг болон мэргэжлийн эмчийн зааврын дагуу зайлшгүй хийгдэх эмчилгээний зардлын 90 хувь даатгагч хариуцна. |
| 10. | <b>Нөхөн сэргээх эмчилгээ</b><br>(Эмчлэгч эмчийн заавраар зайлшгүй хийгдэх нөхөн сэргээх эмчилгээнүүд. Үүнд: бариа засал, зүү төөнүүр, шарлага гэх мэт физик эмчилгээнүүд орно.)   | Зардлын дүнгийн 90 хувь хүртэл  |
| 11. | <b>Сахиурын зардал</b><br>(Шаардлагатай тохиолдолд сахиурын зардал)  | Хоногт 10,000 төгрөг  |
| 12. | <b>Хүүхэд асарсны зардал</b> (0-3 насны хүүхэдтэй даатгуулагчийн хувьд хүүхэд асарсны зардал Гэрээнд тусгайлан зааж өгөх)  | Хоногт 10,000 төгрөг  |
| 13. | <b>Гоо сайхны мэс ажилбарын зардал</b><br>(Гэнэтийн ослоос үүдэн ажилтан гоо сайхны мэс ажилбарт ороход гарах зардлыг хариуцна)  | Зардлын дүнгийн 90 хувь хүртэл  |
| 14. | <b>Уламжлалт эмчилгээ</b><br>(Гэнэтийн ослоос үүдэн ажилтан зайлшгүй шаардлагаар эмнэлэгт хэвтэн уламжлалт эмчилгээ хийлгэх тохиолдолд зардлыг хариуцна)   | Зардлын дүнгийн 80 хувь хүртэл  |
| 15. | <b>Протезийн зардал</b><br>(Гэнэтийн ослоос үүдэн даатгуулагчид протез, хиймэл эрхтэн)   | Зардлын дүнгийн 90 хувь хүртэл  |
| 17. | <b>Гэнэтийн ослоос үүдэлтэй шүдний эмчилгээ</b>  | 1,800,000 төгрөг хүртэл   |
| 18. | <b>Жирэмсний үеийн хүндрэл</b>   | 1,200,000 төгрөгт багтааж тооцно.   |

4.4 Эмнэлгийн ор хоногийн зардлыг төлөхдөө ажилтан үйлчилгээ авсан эмнэлгийн энгийн өрөөний тарифыг баримталж төлнө.

4.5 Даатгалын нөхөн төлбөртэй холбоотой баримт материалыг бүрдүүлж өгөх хугацаа хуанлийн 90 хоног хүртэл байна. Хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд энэ заалт хамаарахгүй.

4.6 Даатгалын нөхөн төлбөр нэхэмжлэхэд бүрдүүлэх бичиг баримт:

4.6.1 Ажилтны Өргөдөл, Даатгуулагчийн албан бичиг



- 4.6.2 Осол, биеийн гэмтэл, өвчлөлийн талаарх мэргэжлийн байгууллагын дүгнэлт, эмнэлгийн акт/магадалгаа эсвэл лист, эмчилгээний карт
- 4.6.3 Он сар өдөртэй эмчилгээний зардал төлсөн дэлгэрэнгүй мөнгөний баримтын хуулбар хувь
- 4.6.4 Өвчний болон эмчилгээ, шинжилгээний дэлгэрэнгүй онош /рентген зураг гэх мэт/
- 4.6.5 Шаардагдах бусад баримт бичиг;

\*Эмнэлгийн хуудас нь “Эмнэлгийн хуудас олгох журам”-д нийцсэн байна.

\*Амбулаторийн карт нь өвчлөл, уг гэмтэл бэртийн эмчилгээний бичилттэй байна.

#### 4.7 Даатгалын нөхөн төлбөрийг шийдвэрлэх:

4.7.1 Даатгагч нөхөн төлбөрийн баримт бичгүүдийг шаардлага хангасан гэж үзвэл ажилтанд ажлын 10 хоногт, эмнэлгийн байгууллагад зардлыг шууд шилжүүлэх тохиолдолд ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэнэ.

4.7.2 Даатгагч нөхөн төлбөртэй холбоотой нэмэлт баримт бичиг, тодруулга шаардлагатай тохиолдолд гэрээний 4.7.1-т заасан хугацааг сунгаж болно.

#### 4.8 Гэрээт хугацаанд Даатгагч дараах байдлаар нөхөн төлбөрийг тооцож даатгалын үнэлгээнд багтаан олгоно.

4.8.1 Дотоод, гадаадын эмнэлэгт оношлуулах, шинжлүүлэх зардал – зардлын дүнгийн 90 хувиар

4.8.2 Амбулаториор эмчлүүлэх, гэрээр хэвтэн эмчлүүлэх үед худалдан авсан эм тарианы үнийн дүнгийн 80 хувиар

4.8.3 Дотоод, гадаадын эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн зардал – зардлын дүнгийн 90 хувиар

4.8.4 Дотоод, гадаадын эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх үед эмчийн заавраар худалдан авсан эм тарианы зардал- зардлын дүнгийн 80 хувиар

4.8.5 Жирэмслэлтийн үеийн хүндрэлээс учирсан зардал- зардлын дүнгийн 60 хувиар

4.8.6 Ослоос учирсан шүдний эмчилгээний зардал- зардлын дүнгийн 90 хувиар.

4.8.7 Гэрээний хугацаанд даатгалын нийт нөхөн төлбөрийн хэмжээ нь нэг ажилтны хувьд 2 сая төгрөгөөс хэтрэхгүй байна.

4.8.8 Ажилтны нэхэмжлэлийг даатгагчаас нөхөн төлөхгүй тохиолдолд үндэслэлийг бичгээр ирүүлж даатгуулагчид мэдэгдэх бөгөөд татгалзах үндэслэл нь нотолгоотой байна.

### ТАВ. ХАСАЛТ ХЭСЭГ

- 5.1 Ажилтан гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдэхээр завдсан үед учирсан осол гэмтэл;
- 5.2 Согтууруулах ундаа, мансууруулах бодис болон эм хэтрүүлэн хэрэглэсэн, жолоодох эрхгүй хүнд жолоогоо дур мэдэн дамжуулсны улмаас даатгалын тохиолдол бүрдсэн; Архи болон никотин эсвэл тамхины хамааралтай эмчилгээ;
- 5.3 Мэргэжлийн спортын уралдаан тэмцээн/байгууллагаас зохиодог нийтийн спортын тэмцээн, арга хэмжээ хамаарахгүй/, мөн бүхий л дотоод шаталтын хөдөлгүүртэй тээврийн хэрэгслээр уралдаан тэмцээнд оролцсон, уулын спорт, агаарын спорт болон шүхрийн спортод оролцсоны улмаас үүссэн осол гэмтэл;
- 5.4 Ан хийх үед гарсан осол гэмтэл;
- 5.5 Сэтгэл санааны саатал, сэтгэц мэдрэлийн өвчин, унах татах өвчин, Байнгын хяналтад байдаг артерийн даралт ихсэх өвчтэй /ischemic strok-ишемийн инсульт/ болон өмнө нь хэсэгчлэн цус харваж байсан өвчтөний хувьд цус харвалт,
- 5.6 Даатгалын тохиолдол мөн эсэх нь нотлогдоогүй буюу нотлогдох боломжгүй болсон.
- 5.7 Даатгуулагч нь даатгалд хамрагдахаас өмнөх ослын улмаас олсон гэмтлийн урхаг, хор нөлөөг эдгэрүүлэх, сэргийлэх үүднээс дахин эмчилгээ хийлгэн эмнэлэгт хэвтсэн, амбулатори болон гэрээр эмчлүүлсэн бол;
- 5.8 Туршилтын батлагдаагүй эм тариа хэрэглэсний үр дагавар, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн: витамин, уураг, эрдэс, органик бодисууд гэх мэт.
- 5.9 Гэрээнд заасан өвчинтэй холбоогүй нойрны эмчилгээ, амралт сувилал, ядаргаа тайлах эмчилгээ, массаж, Вакцинжуулалт, хэл ярианы заслын эмчилгээ, төрөлхийн гажиг, төрөлхийн өвчин, удамшлын өвчин, хөгжлийн бэрхшээлтэй байх;
- 5.10 Жин нэмэх, хасах үйлчилгээ, Хараа, сонсгол шалгуулах, линз, сонсголын аппарат хэрэгслийн зардал;
- 5.11 Архаг хууч өвчин болон даатгалын гэрээ эхлэхээс өмнө авч байсан бэртэл гэмтэлтэй холбоотой эмчилгээ.
- 5.12 Төрөлт болон төрөлтийн хүндрэлтэй холбоотой зардал
- 5.13 Оршуулгын зардал;
- 5.14 Хорт хавдраар өвчилсөн, элэгний В, С вирус тээгчийн улмаас байнгын хяналтад байдаг өвчлөл;
- 5.15 Эд эрхтэн шилжүүлэн суулгах, нөхөн сэргээх болон гэрээнд заасан өвчинтэй холбоогүй гоо сайхны мэс засал;
- 5.16 Гормон орлуулах эмчилгээ;





- 5.17 Төрөлтийг зохицуулахаар хэрэглэж буй мэс заслын механик эсвэл химийн гаралтай жирэмслэлтээс хамгаалах аргууд эсвэл үргүйдэлтэй холбоотой эмчилгээ болон зохиомлоор үр тогтоох эсвэл үр тогтоох чадваргүй болгох буюу стерилизаци, бэлгийн хөрөлт, сулралын эмчилгээ;
- 5.18 ХДХВ-ын халдвар, ДОХ-ын өвчлөл болон түүнтэй холбоотой гарч болох оношилгоо эмчилгээний зардлууд болон генетикийн хувирал өөрчлөлт болон хувьслын дүнд үүссэн ямар нэгэн мутант;
- 5.19 Бэлгийн замаар халдварлах өвчин, хөл хорио тогтоох;
- 5.20 Галзуу өвчин, зөнөгрөх өвчинтэй холбоотой эмчилгээний зардлууд. Бүх төрлийн сэтгэл гутрал, эмгэг айдас өвчин, мэдрэлийн гаралтай хоолны дуршилгүй болох, эмгэг ховдоглох өвчин, шизофрени, зан үйлийн эмгэг өөрчлөлтүүд; хөгшрөлттэй холбоотой өвчлөлүүд. Үүнд: альцгеймер, ясны сийрэгжилт болон түүнтэй төстэй өвчлөлүүд г.м;
- 5.21 Хиймэл эрхтэн эсвэл ортопедын аппарат хэрэгсэл, эмнэлгийн тусламж эсвэл удаан эдэлгээ бүхий эмнэлгийн төхөөрөмжөөр хангах зардал;
- 5.22 Бөөрний дутагдлаас бусад үеийн бөөрний диализ;
- 5.23 Эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгийн төлбөр;
- 5.24 Гэрээний хугацаа дууссаны дараа гарсан эмчилгээ үйлчилгээ;

## ДААТГАЛЫН ТОХИОЛДЛЫН ҮЕД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Даатгалын тохиолдлын үед яаралтай авах арга хэмжээ:

Даатгалын тохиолдлын үед даатгуулагч дараах арга хэмжээг нэн даруй авна:

- Даатгагчид нэн даруй 72 цагийн дотор мэдэгдэнэ.
- Холбогдох мэргэжлийн байгууллагад мэдэгдэх (цагдаа, гал түймэртэй тэмцэх алба болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагууд)
- Хохирлыг багасгахтай холбогдсон бусад бүх үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх
- Даатгагчид хохирлын талаарх дараах баримт мэдээллийг явуулна.
  - a. Гарсан хохирлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг бичгээр;
  - b. Гэрчлэх баримт, бусад холбогдох материалыг;
  - c. Шаардлагатай бол мэргэжлийн байгууллагын үнэлэлт, дүгнэлт

Даатгалын нөхөн төлбөр олгох материал дутуу, хангалттай биш гэж үзсэн тохиолдолд даатгагч нөхөн төлбөр олгох хугацааг хойшлуулах эрхтэй.

Гэмтэл бэртэлтэй холбоотой гэнэтний ослын үед авах арга хэмжээ

- 1) Хүний амь нас, эрүүл мэндтэй холбоотой нөхцөл байдлын үед шаардагдах түргэн тусламжийг яаралтай үзүүлэх  
Түргэн тусламж, холбогдох мэргэжлийн байгууллагад мэдэгдэх
- 2) Даатгалын тохиолдол болсон газар боломжтой бол:  
Холбогдох баримт нотолгоо болох эд зүйлийг шинжлэн дүгнэх, шуурхай албаны хүмүүс иртэл хөндөхгүй, хэвээр байлгах.  
Түүнд оролцсон болон гэрчийн мэдүүлгийг үнэн зөвөөр авах.  
Тохиолдол болсон цаг хугацаа, газар, хэн бэртсэн гэмтсэн, нас барсан, ямар зүйл хохирсон талаар дэлгэрэнгүй мэдээлэл.  
Ямар ч хохирлын үед Шуурхай албанд нэн даруй яаралтай мэдэгдэж байх
- 3) Хохирлын нэхэмжлэлийг хүлээн авах, шийдвэрлэх, даатгалын тохиолдлын үед түргэн шуурхай ажиллах 24 цагийн дуудлага хүлээн авах үүргийг Шуурхай Алба гүйцэтгэнэ.

### ХАЯГ:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,

5-р хороо, Үндсэн хуулийн гудамж,

4 – 2 тоот Таван Өндөр Төв

Утас: 976-70004800

Шуурхай албаны утас: 9905 4800

Email:

### ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТУУД

Гэрээний Хавсралтууд:

Хавсралт 1 Гэнэтний ослын даатгал, Эмнэлэг эмчилгээний зардлын даатгалд хамрагдах ажилтны нэрс

Хавсралт 2 Гэрээний сургалтын хөтөлбөр болон эрсдэл шилжүүлэх арга хэмжээ

Хавсралт 3 Даатгалын тохиолдлыг баталгаажуулах акт /загвар/

Хавсралт 4 Осол, осолд дөхсөн тохиолдлын судалгаа шинжилгээний тайлан /загвар/





ДААТГАЛД ХАМРАГДАХ АЖИЛЧДЫН НЭРС

| №  | Салбар  | Овог нэр        | Р.Д:       | Албан тушаал                                    | ГӨД-н үнэлгээ | Хураамж   | ЭЗД-ын үнэлгээ | Хураамж   |
|----|---------|-----------------|------------|---|---------------|-----------|----------------|-----------|
| 1  |         | И.Батболд       | ТГ63083112 | Үйлдвэрийн захирал                              | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 2  |         | Л.Цэдэнсодном   | ФМ54111250 | Үйлдвэрийн захирлын орон тооны зөвлөх           | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 3  |         | Ц.Галсүрэн      | ИО84052813 | Ерөнхий инженер                                 | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 4  |         | Б.Бадрах-Эрдэнэ | ФМ80121733 | Захирагааны менежер                             | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 5  |         | Д.Жаргалсайхан  | ФБ99042902 | Хуульч  | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 6  |         | Ц.Даваадорж     | ФМ87080271 | Хүний нөөцийн ажилтан                           | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 7  |         | Б.Мөнхчимэг     | ФЖ00292608 | Хүний нөөцийн ажилтан                           | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 8  |         | Т.Мөнхчимэг     | АН94032604 | Туслах ажилтан                                  | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 9  |         | Б.Амарзаяа      | ФА92051358 | Мэдээлэл технологийн инженер                    | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 10 |         | А.Наранцэцэг    | ЧВ85061366 | Гүйцэтгэх нарийн & бичиг хэрэг, архивын ажилтан | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 11 |         | Г.Төгөлдөр      | ФА95032238 | Үйлдвэрийн захирлын туслах                      | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 12 |         | Б.Наранцогт     | ГИ95091515 | Ерөнхий инженерийн туслах                       | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 13 |         | О.Чулуунням     | ФМ66041011 | Туслах ажилтан                                  | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 14 |         | Л.Азжаргал      | ИЦ74101605 | Ахлах нягтлан бодогч                            | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 15 | ЭРДЭНЭТ | П.Болорцэцэг    | ФБ79080108 | Тооцооны нягтлан бодогч                         | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 16 |         | Б.Г.Эрэлмаа     | ФМ84022162 | Тооцооны нягтлан бодогч /бараа материал/        | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 17 |         | М.Жаргал        | ДП87081034 | Зардлын шинжээч                                 | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 18 |         | Э.Мөнхцоож      | УО87121110 | Агуулахын ахлах ажилтан                         | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 19 |         | Б.Лхагвабаяр    | НТ89020819 | Хангамжийн ажилтан                              | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 20 |         | М.Баттэгш       | ИЛ95111617 | Хангамжийн ажилтан                              | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 21 |         | П.Осоржамбаа    | ГЮ87040928 | Химийн материалын нярав / ажилтан               | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 22 |         | Н.Баасандорж    | ГИ92062612 | Сэлбэг хэрэгслийн нярав / ажилтан               | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 23 |         | Д.Ганбаяр       | ОД70121911 | Ачигч   | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 24 |         | З.Банзрагч      | АО73062913 | Ачигч   | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 25 |         | Б.Золбаяр       | ФД88021313 | Ачигч   | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 26 |         | Ш.Эрдэнэбаяр    | ФД87051611 | Ачигч   | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 27 |         | Ж.Мөнхдархан    | ТЖ81021911 | Хабзабо-н менежер                               | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 28 |         | Б.Нэмэхбаяр     | ФБ86100532 | Хаб-ын ахлах ажилтан                            | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 29 |         | Н.Энхтөр        | ФА82061071 | Хаб-ын ажилтан                                  | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |
| 30 |         | Л.Сүхбаатар     | ФА56112818 | Хабза-н сургагч                                 | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00   | 40,000.00 |




|    |                |            |  |               |           |              |           |
|----|----------------|------------|--|---------------|-----------|--------------|-----------|
| 31 | Ч.Гүрэмваа     | ЦА66031001 | Эмч                                      | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00 | 40,000.00 |
| 32 | О.Буюнхишиг    | ЛЙ89051562 | Эрүүл ахуйч                              | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00 | 40,000.00 |
| 33 | Г.Явуухулан    | ФЖ86041519 | Галын аюулгүй байдлын ажилтан            | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00 | 40,000.00 |
| 34 | П.Буйан-Очир   | ФЖ81032911 | Галын аюулгүй байдлын ажилтан            | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00 | 40,000.00 |
| 35 | Г.Нарангэрэл   | ВЮ92080312 | Байгаль орчны ажилтан                    | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00 | 40,000.00 |
| 36 | Н.Жавхлантөгс  | ФА89032874 | Туслах ажилтан                           | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00 | 40,000.00 |
| 37 | Б.Батмөнх      | ФБ97090930 | Туслах ажилтан                           | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00 | 40,000.00 |
| 38 | П.Очирбат      | АР81030819 | Судалгаа шинжилгээ, төлөвлөлтийн менежер | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00 | 40,000.00 |
| 39 | С.Энхцол       | ПЮ85092713 | Металлургийн ахлах инженер               | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00 | 40,000.00 |
| 40 | Э.Бямбажав     | РЙ93031312 | Металлургич                              | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00 | 40,000.00 |
| 41 | Б.Эрдэнэ-Уул   | ФА93100311 | Уулын ашиглалтын инженер                 | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00 | 40,000.00 |
| 42 | Т.Тэмүүжин     | ФБ97110939 | Судалгааны ажилтан                       | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00 | 40,000.00 |
| 43 | Ж.Эрдэнэчимэг  | ГЮ88012107 | Химийн лабораторийн эрхлэгч              | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00 | 40,000.00 |
| 44 | Э.Оюунтулхүүр  | НБ95111405 | Химич лаборант                           | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00 | 40,000.00 |
| 45 | М.Гарамжав     | ИГ96031404 | Химич лаборант                           | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00 | 40,000.00 |
| 46 | Б.Мөнхзул      | МВ86121601 | Химич лаборант                           | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00 | 40,000.00 |
| 47 | О.Сугар        | ГЮ91051714 | Химич лаборант                           | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00 | 40,000.00 |
| 48 | П.Тунгалагтуяа | ФБ97071940 | Химич инженер                            | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00 | 40,000.00 |
| 49 | Б.Мөнхбаяр     | ФБ97040318 | Лаборант                                 | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00 | 40,000.00 |
| 50 | Б.Мандах       | ХЕ57111571 | Төслийн хяналтын ахлах инженер           | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00 | 40,000.00 |
| 51 | П.Энхдаваа     | ЦЕ85051812 | Төслийн инженер                          | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00 | 40,000.00 |
| 52 | Б.Батзаяа      | ФВ95022411 | Төслийн зохицуулагч                      | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00 | 40,000.00 |
| 53 | Б.Янжинсүрэн   | ГЮ92060109 | Зургийн инженер                          | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00 | 40,000.00 |
| 54 | Б.Сарнай       | ФМ83032021 | Химич лаборант                           | 10,000,000.00 | 45,000.00 | 2,000,000.00 | 40,000.00 |
